



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН

2024 ОНЫ 08 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 08 дугаар сарын 19-ний өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-8
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9-37
<hr/>	
1.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжлэв/	10-11
2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нарын 6 гишүүн 2024.08.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/	11
3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлт /үргэлжлэв/	11-12
4.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	12-36
5.“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	36-37

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
08 дугаар сарын 19-ний өдөр /Даваа гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 71 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 08 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: С.Бямбацогт, Ж.Галбадрах, Ж.Ганбаатар, Д.Ганмаа, Б.Мөнхсоёл, Б.Пүрэвдорж, Г.Тэмүүлэн;

Чөлөөтэй: Х.Баттулга, Э.Болормаа, О.Номинчимэг, С.Одонтуяа, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан, Н.Учрал;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Лүндэг, Н.Наранбаатар;

Тасалсан: Н.Алтаншагай, Д.Батлут, Э.Батшугар, З.Мэндсайхан.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан эхлэх цаг болсон тул хуралдаанд цагтаа ирээгүй гишүүдийн нэрсийг танилцуулав./10:00-10:06/

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн байна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 27

Бүгд: 76

64.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг хуралдаанд оролцсон

гишүүдийн олонх дэмжсэн тул хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нарын 6 гишүүн 2024.08.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, дэгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Наранцэцэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 14
Бүгд: 78

82.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Ёс зүй, дэгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлт /үргэлжлэв/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийн талаарх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.3-т заасны дагуу санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: 1.Цагдаагийн албаны тухай хуулийн 26.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 26.1-д заасан хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 13 дахь заалтын

“халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ...” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 18
Бүгд: 87
79.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Цагдаагийн албаны тухай хуулийн 26.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 26.1-д заасан хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэдийнхээ өмнө хариуцна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 11
Бүгд: 87
87.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.3-т заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн тул энэ тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:18/

Уг асуудлыг 10 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Төсвийн байнгын хороо хуралдах тул хуралдаан 10 цаг 19 минутад завсарлав.

Хуралдаан 15 цаг 09 минутаас үргэлжлэв.

Дөрөв.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Нийслэлийн Засаг даргын Эдийн

засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Н.Мандуул, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Соёлын яамны Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Даваажаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хяналт шалгалтын багийн ахлах хянан шалгагч Т.Нармандах, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Энхжин, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын зөвлөх Б.Батхуяг, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга М.Батбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Б.Энхбаяр, М.Энхцэцэг, Ж.Баясгалан, Б.Найдалаа, Дав.Цогтбаатар, О.Амгаланбаатар, Б.Жаргалан, Ц.Мөнхбат, М.Бадамсүрэн нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул нар хариулж, тайлбар хийв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Төрийн өмчийг Нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай”, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 60

Бүгд: 104

42.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Г.Дамдинням нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Г.Дамдинням нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 50

Бүгд: 104

51.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Төрийн өмчийг Нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай”, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явууля.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 49

Бүгд: 104
52.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан танилцуулав.

Д.Амарбаясгалан: “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 49
Бүгд: 104
52.9 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./16:38/

Уг асуудлыг 16 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 1 цаг 40 минут үргэлжилж, 126 гишүүнээс 106 гишүүн хүрэлцэн ирж, 84.1 хувийн ирцтэйгээр 16 цаг 38 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

**ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА**

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 19-ний өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 08 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: 19-ний 10 цагт зарлагдсан, ингээд 10 цаг болсон байна. Чуулганы хуралдаанд 126 гишүүн ирэх ёстойгоос 36 гишүүн ирсэн байна. Ирээгүй гишүүдийн нэрсийг дуудъя. Жуковын Алдаржавхлан, Сайнбуянгийн Амарсайхан, Норовын Алтанхуяг, Очирбатын Амгаланбаатар, Наранцэцэгийн Алтаншагай, Чинбаатарын Анар, Цэндийн Баатархүү, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Далайн Батбаяр, Жигжидийн Батжаргал, Дамбын Батлут, Отгоншарын Батнайрамдал, Жадамбын Батсуурь, Нацагдоржийн Батсүмбэрэл, Халтмаагийн Баттулга, Батмөнхийн Батцэцэг, Пүрэвийн Батчимэг, Энхбаярын Батшугар, Жудагийн Баярмаа, Жадамбын Баясгалан, Хөххүүгийн Болормаа, Энхбатын Болормаа чөлөөтэй байгаа. Шинэбаярын Бямбасүрэн, Сандагийн Бямбацогт, Жанчивын Галбадрах, Гомбын Ганбаатар, Дашдондогийн Ганбат гишүүн чөлөөтэй байгаа. Пүрэвжавын Ганзориг, Даваасамбуугийн Ганмаа чөлөөтэй байж байгаа. Лувсаннямын Гантөмөр, Мөнгөнцогийн Ганхүлэг, Цэрэнпилийн Даваасүрэн, Гонгорын Дамдинням, Тогмидын Доржханд, Борхүүгийн Дэлгэрсайхан, Жангабыл, Батбаярын Жаргалан, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Батжаргалын Заяабал, Жаргалсайханы Золжаргал, Ганзоригийн Лувсанжамц, Сүрэнжавын Лүндэг, Загджавын Мэндсайхан, Цагаанхүүгийн Мөнхбат, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Баатаржавын Мөнхсоёл, Пүрэвбаатарын Мөнхтулга,

Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Бадрахын Найдалаа, Нанзадын Наранбаатар, Мөнхтөрийн Нарантуяа-НАРА, Одсүрэнгийн Номинчимэг, Нямтайширын Номтойбаяр, Салдангийн Одонтуяа, Ганбатын Очирбат, Бадамдоржийн Пунсалмаа, Даваахүүгийн Пүрэвдаваа, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Отгоны Саранчулуун, Мягмардашийн Сарнай, Ренчинбямбын Сэддорж, Цэвэгдоржийн Туваан, Банзрагчийн Түвшин, Чинбатын Ундрал, Ганбатын Хосбаяр, Даваагийн Цогтбаатар, Дамдины Цогтбаатар, Одонгийн Цогтгэрэл, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Баттогтохын Чойжилсүрэн, Доржзовдын Энхтуяа, Сүхбаатарын Эрдэнэбат, Сүхбаатарын Эрдэнэболд, Равжихын Эрдэнэбүрэн гэсэн гишүүд танхимдаа ирье.

Манай гишүүд яагаад хоцорч орж ирээд байна вэ? Чуулганы хуралдаан 10 цагт зарлагдсан. Одоо 10 цаг 5 минут болж байна. Бүлгийн хурлаа чуулганы хуралдаанаас дээгүүр тавихгүй байхыг хүсье. Чуулганы хуралдаан 10 цагт зарлагдсан.

Жуковын Алдаржавхлан, Норовын Алтанхуяг, Наранцэцэгийн Алтаншагай, Сайнбуянгийн Амарсайхан, Очирбатын Амгаланбаатар, Цэндийн Баатархүү, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Далайн Батбаяр, Жигжидийн Батжаргал, Дамбын Батлут, Жадамбын Батсуурь, Нацагдоржийн Батсүмбэрэл, Халтмаагийн Баттулга, Батмөнхийн Батцэцэг, Пүрэвийн Батчимэг, Энхбаярын Батшугар, Жудагийн Баярмаа, Хөххүүгийн Болормаа, Энхбатын Болормаа, Шинэбаярын Бямбасүрэн, Сандагийн Бямбацогт, Жанчивын Галбадрах, Гомбын Ганбаатар, Даваасамбуу, Лувсаннямын Гантөмөр, Мөнгөнцогийн Ганхүлэг, Цэрэнпилийн Даваасүрэн, Тогмидын Доржханд, Батбаярын Жаргалан, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан,

Батжаргалын Заяабал, Жаргалсайханы Золжаргал, Сүрэнжавын Лүндэг, Загджавын Мэндсайхан, Баатаржавын Мөнхсоёл, Пүрэвбаатарын Мөнхтулга, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Нанзадын Наранбаатар, Мөнхтөрийн Нарантуяа-НАРА, Чинбатын Номин, Одсүрэнгийн Номинчимэг, Нямтайширын Номтойбаяр, Салдангийн Одонтуяа, Ганбатын Очирбат, Даваахүүгийн Пүрэвдаваа, Пүрэвжавын Сайнзориг, Мягмардашийн Сарнай, Цэвэгдоржийн Туваан, Ганзоригийн Тэмүүлэн, Банзрагчийн Түвшин, Чинбатын Ундрам, Дамдины Цогтбаатар, Одонгийн Цогтгэрэл, Баттогтохын Чойжилсүрэн, Доржэзовдын Энхтуяа гишүүд танхимдаа ирье. Засгийн газрын гишүүд ирэхгүй болбол санал хураалт ирц бүрдсэн байна. Шууд санал хураалтдаа орлоо шүү.

Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгаж, өнөөдрийн хуралдаа 126 гишүүнээс 71 гишүүн ирж, 56,3 хувиар ирц бүрдсэн тул хуралдааныг 8 сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдааныг эхлүүлэе.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар өнөөдөр 5 асуудлыг хэлэлцэнэ. 1 дүгээрт Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хийнэ. 2 дугаарт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. 3 дугаарт Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 3 дугаар дүгнэлтийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. 4 дүгээрт Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн, хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. 5 дугаарт Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын

төслийг хэлэлцэнэ. 5 асуудал хэлэлцэхээр байна.

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Ингээд хэлэлцэх асуудал 1 дүгээрт оръё. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Нэг дэх хэлэлцүүлэг явагдаж байгаа. Улсын Их Хурлын гишүүд 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар төсвийн төслийн талаарх илтгэл дүгнэлт болон төсвийн төсөлтэй холбогдуулан Ерөнхий сайд, Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, хариултыг авч, үг хэлж дууссан байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70.5-д заасны дагуу төсвийн төсөл нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалтыг явуулна. Иймд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн байна гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна.

Дахиад тодотгож хэлье. Иймд Төсвийн тухай болон Төсвийн

тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн байна гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна. Санал хураалт. 76 гишүүн санал хураалтад оролцоноос 49 гишүүн дэмжиж, 64,5 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай тухай хуулийн төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон Байнгын хороодод мөн Төсвийн зарлагын дэд хороонд шилжүүллээ. Энэ дэд хорооныхоо даргыг өнөөдөр Байнгын хороогоор яаралтай шийднэ тийм ээ.

10.12 цаг

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нарын 6 гишүүн 2024.08.14-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/

Ингээд хэлэлцэх асуудал 2-т оръё. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. Хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалтыг явуулна.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал

хураалтыг явуулна. Санал хураалт. Санал хураалтад 78 гишүүн оролцож, 64 гишүүн дэмжсэнээр санал дэмжигдлээ. Баясгалан гишүүний төхөөрөмж ажиллаагүй гэж байна. Техникийн хүмүүс очиж тусалъя. Өгсөн саналаа протоколд тэмдэглүүлж болно.

Ингээд хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Ёс зүй, дэгийн байнгын хороонд шилжүүллээ.

10.14 цаг

Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлт /үргэлжлэв/

Хэлэлцэх асуудал 3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 3 дугаар дүгнэлтийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар гишүүд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт ХЗБХ-ны санал, дүгнэлттэй танилцсан. Байнгын хорооны саналаар санал хураалтыг явуулна.

Санал хураалтад 1 дүгээрт Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт энэ хуулийн 26.1-д заасан хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Энэ 2 санал хураалттай. Эхний санал хураалт нь 87 гишүүнээс

санал хураалтад оролцсоноос 69 гишүүн буюу 79,3 хувиар дэмжигдлээ.

2 дахь санал хураалтад орёё. 2.Цагдаагийн албаны тухай хуулийн 26.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 26.1-д заасан хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Монгол Улсын үндсэн хуулийн Арван есдүгээр дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэдийнхээ өмнө хариуцна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Ингээд санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 76 гишүүн дэмжиж, 87,4 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Байнгын хорооны саналаар санал хурааж дууслаа. Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталсанд тооцлоо. Уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тогтоол 2024 оны 8 дугаар сарын 19-ний өдөр, Улаанбаатар хот.

Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийн тухай. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

1.Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт энэ хуулийн 26.1-д заасан хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцон заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтын халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшигөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний

эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасныг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.18 цаг

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлаар Төсвийн байнгын хороо хуралдах ёстой байгаа. Төсвийн байнгын хуралдаж хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэсний үндсэн дээр Улсын Их Хурлын нэгдсэн чуулган үргэлжилнэ. Тийм учраас цаг 10 цаг 18 минут болж байна. 11 цаг 30 минут хүртэл завсарлахад болох уу Даваасүрэн дарга? 11 цаг 30 минут хүртэл Улсын Их Хурлын нэгдсэн чуулган түр завсарлалаа.

Төсвийн байнгын хороо хуралдах тул хуралдаан 10 цаг 19 минутад завсарлав.

Хуралдаан 15 цаг 09 минутаас үргэлжлэв.

Ж.Амарбаясгалан: Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы үдээс хойших хуралдааныг эхлүүлъя. Сая Төсвийн байнгын хороо хуралдаж, 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэж, санал хураалтыг явуулсан байна.

Дөрөв.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар

*2024.08.12-ны өдөр өргөн
мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

Одоо бид чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Жавхлан: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт 13 хуулийн төсөл, 2 Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийн талаар товч танилцуулъя.

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн анхдугаар чуулганы нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай хууль, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн холбогдох бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн баталж, Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудалд өөрчлөлт орсон билээ. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Түүнчлэн оновчтой үр ашигтай засаглалыг бэхжүүлэх, Засгийн газрын харьяа байгууллага, албан тушаалтан, албаны чиг үүргээ хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж байгаа эсэхэд Засгийн газрын хэрэгжүүлэх байгууллага хяналт тавих тогтолцоог оновчтой болгох хүрээнд Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

2. Тухайн жилийн төсвийн төслийг боловсруулахад олон нийтийн оролцоог хангах зохицуулалтыг сайжруулж, салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд өөрсдийн салбарын төсвийн төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулдаг байх, Төсвийн цаглаврыг төсөв боловсруулах, хянах, дүгнэлт гаргах, хэлэлцүүлэх үйл явцдаа нийцүүлэх, төрийн үйлчилгээний бүтээмж, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн механизмыг бүх салбарт хэрэгжүүлэх боломжтой байх зэрэг зохицуулалтыг Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгалаа.

Нийгэмд чиглэсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрүүдийг өөрийн хөрөнгөөр санаачлан хэрэгжүүлсэн албан татвар төлөгчийн элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт болон харилцан хамааралгүй этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг тухайн жилийн татвар ногдох орлогын нэг хувиас хэтрэхгүй дүнгээр үйл ажиллагааны орлого төлбөл зохих албан татвараас хасаж хөнгөлөх зохицуулалтыг Аж ахуйн нэгжгийн орлого албан татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд мөн тусгалаа.

3. Монгол Улсын хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжих бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийн

худалдан авах ажиллагааг чадавхад суурилсан хэлэлцээний аргаар зохион байгуулж, тендер шалгаруулалтад туршлага, чадавх, нэр хүнд бүхий ААН-ийг урьж оролцуулах нөхцөлийг бүрдүүлж, бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийг хурдан шуурхай гүйцэтгэх зохицуулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд тусгалаа.

Түүнчлэн нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээг хэвийн, тасралтгүй хангах нэн яаралтай нөхцөл үүссэн тохиолдолд сонгон шалгаруулалт зарлахгүйгээр төслийг хэрэгжүүлэх чадвартай 2-оос доошгүй хувийн хэвшлийн түншлэгчид урилга хүргүүлж, төслийн санал авч хэлэлцээ хийж, хамгийн сайн нөхцөл санал болгосон түншлэгчтэй гэрээ байгуулах зохицуулалтыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгалаа.

Нийслэл хотын аж ахуй, инженер хангамжийн бараа, ажил үйлчилгээг тухайн салбарын төрийн болон ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлэх ажлыг түргэн шуурхай эхлүүлэх зохицуулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай хуулийн өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөлд тусгалаа.

4. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр ус, цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлийн давтамж, эрч эрчим, эрчим хүч нэмэгдсэн өнөөгийн нөхцөлд нийслэл Улаанбаатар хотод үүсэж болзошгүй гамшигийн эрсдэлийг бууруулах, хор уршиг, үр дагавраас урьдчилан сэргийлэх, хойшлуулшигүй

сэргээн босгох ажлыг нэн даруй хэрэгжүүлэхтэй холбогдуулан Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулаа.

5. Шахмал түлшний хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт, түгээлт болон эдгээр үйл явцад тавих хяналт түүнчлэн санхүүжилтийн механизмыг сайжруулах зорилгоор энэхүү үйл ажиллагааг эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн төрийн эзэмшлийн хувийг нийслэлийн өмчлөлд шилжүүлж, үйл ажиллагаа үйлдвэрлэлийг нийслэлд хариуцуулахаар Төрийн өмчийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулан хэлэлцүүлж байна.

Хуулийн төслүүд батлагдсанаар Засгийн газрын үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж, хамтарсан Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөгжлийг хурдасгах, хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд цаг алдалгүй шуурхай, үр дүнтэй хэрэгжих боломж бүрдэх болно.

Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэлд өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төслүүдийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр

Улсын Их Хуралд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төрийн өмчийг нийслэлийн өмчид шилжүүлэх тухай, Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтэц, ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа яаралтай горимоор хэлэлцлээ.

Хууль санаачлагчаас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсантай холбогдуулан дээрх хууль, тогтоолын төслүүдийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар төсвийн суурь тэнцэл, төсвийн суурь зарлага гэсэн ойлголтуудын талаар, цалин хөлс, нийгмийн суурь зардал зэрэг төсвийн урсгал зардлыг бууруулж, хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлж байгаа шалтгаан, эдгээр нь төсвийн зардлын хэдэн хувийг бүрдүүлж байгаа талаар. Төсвийн орлого нэмэгдэж байгаатай холбогдуулан хувь хүний орлогын албан татварыг хэрхэн нэмэгдүүлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд оруулсан сонгон шалгаруулалтыг 2 удаа зарлаад хувийн хэвшил оролцоогүй тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит компанийг сонгохоор заасан нь хувийн хэвшлийг дэмжиж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг өөрчлөхгүйгээр улсын 2024 оны төсвийн тодотголыг оруулж ирэх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуульд заасан Ирээдүйн өв сангийн хуримтлалыг хэрхэн үр өгөөжтэй байлгах талаар, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтүүд нь хувийн хэвшилд хаалттай эрх зүйн орчин бий болгож байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж

мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хүчингүй болсон Концессын хуультай зөрчилдөж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн тухай хуульд заасан төсвийн цаглаварт оруулсан өөрчлөлт нь Улсын Их Хурлын төсөв батлах бие даасан эрхийг хязгаарлаж, батлах хугацааг богиносгож байгаа шалтгаан, Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь үндэсний хувийн хэвилийг дэмжиж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Гомбын Ганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Үндэсний аудитын газрын дүгнэлт гарсан байхад дагасан хуулиудыг хэлэлцэх нь зөв эсэх, Төрийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахад хувийн хэвилийн зэрэгцээ төрийн болон орон нутгийн өмчит компаниуд оролцож байгаа нь зөв эсэх талаар тус тус асуулт асууж хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэхийг дэмжинэ, харин ажлын хэсэг боловсруулалтын явцад сайжруулах, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг нийгэмд буруу зөрүү ойлголт өгөхөөр тайлбарлаж байгаад Засгийн газар дүгнэлт хийх, өмнө нь батлагдсан 6.4 дэх хэсгийн бичилтийг хууль зүйн техникийн хувьд боловсронгуй болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Тендерийн хуулиар биш Засгийн газар дангаараа гэрээ хэлцэл хийх үр дагаврыг бий болгож байгаа тул эдгээр хуулиудыг дэмжих боломжгүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Уянгахшиг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсний дараа дагаж мөрдөх,

дагаж өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хуулийг өөрчлөхгүйгээр одоо дагаж мөрдөж байгаа хуулийн хүрээнд төсвийн тодотголыг хэлэлцэх, Тендерийн хуулийн төслийг нарийвчлан хэлэлцэх, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Тендерийн хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжээд бусад хуулийн төслийг сайн судалж, боловсронгуй болгох, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн тендерийн болон концессын үйл ажиллагааг зохицуулсан хууль болон зарим хуулийн төслүүдэд хууль, эрх зүйн дүгнэлт гаргах шаардлагатай гэсэн саналыг тус тус гаргасан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн дээрх хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх талаар Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Лувсаннъямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Тогмидын Доржханд Монгол Улсын Шадар сайд, Равжихын Эрдэнэбүрэн Монгол Улсын сайд 20 минутын хот Үндэсний хорооны дарга, Болдын Жавхлан Сангийн сайд,

Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн хөгжлийн сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нямдэлэгийн Мандуул Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч, Баасанжавын Батхуяг Хяналт үнэлгээний үндэсний хорооны даргын зөвлөх, Доржсүрэн Хорлоогийн Саруул ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга, Цэдэнбалын Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засгийн хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хөрөнгө оруулалтын газрын дарга, Адъяасүрэнгийн Даваажаргал Соёлын яамны Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жигжидсүрэнгийн Отгонбат Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалт газрын дарга, Төмөрбаатарын Нармандах Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын хяналт шалгалтын багийн ахлах хянан шалгагч, Дугаржавын Амгалан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Болдбаатарын Энхжин НЗД-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Мөнхөөгийн Батбаяр Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга. Энэ ирээгүй байгаа ажлын хэсгийн гишүүдийг дуудаарай.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын

хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. Нийт 17 гишүүн асуулт асуухаар нэр ирсэн байна. Ирсэн ирцээрээ эрэмбэлэгдсэн үү гишүүд? Баттөмөрийн Энхбаяр гишүүн алга байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн үгээ хэлье, асуултаа асууна тийм ээ.

С.Ганбаатар: 1 дүгээрт Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль орж ирж байгаа. 37.1.3-д нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээг хэвийн, тасралтгүй хангаж, нэн яаралтай нөхцөл үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан аргаар төслийг зарлаж, сонгон шалгаруулах хугацааг мөрдөх боломжгүй гэсэн үг байгаа. Энэ дээр хууль, эрх зүйн тайлбарыг надад өгнө үү энэ дээр.

2 дугаарт Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуульд нийтийн зориулалттай дэд бүтэц гэдэг дээр нэн яаралтай нөхцөл үүссэн тохиолдолд сонгон шалгаруулалт зарлахгүйгээр төслийг хэрэгжүүлэх чадвартай 2-оос доошгүй хувийн хэвилийн түншлэгчид урилга хүргүүлж, хэлэлцээ хийж хамгийн сайн нөхцөлд санал болгосон түншлэл гэрээ байгуулах боломжийг нэмэлтээр тусгасан болно гэж байгаа юм. Энэ 2 дээр та бүхэн яг эрх зүйн тайлбарыг ямар үндэслэлээр вэ гэдгийг гаргаж өгнө үү.

3 дугаарт Төрийн өмчийг нийслэлийн өмчид шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар би бас тодруулж асуумаар байна. Энэ дээр Эрдэнэс тавантолгой ХК-аас авсан санхүүжилт 1 их наяд 242 тэрбум төгрөг, ингээд хуримтлагдсан алдагдал 790 тэрбум төгрөг тус тус байна гэж байгаа юм. Үүнийг Тавантолгой түли ХК-ийг нийслэлийн өмчид шилжүүлэхэд энэ асуудал гарах уу, энэ асуудал ямар нэгэн байдлаар

бэрхшээл бий болох уу, энэ хуримтлагдсан алдагдал өрийн талаар шийдэл гаргасан зүйлүүд байгаа юу гэсэн ийм 3 зүйлийг би тодруулж асуугаад, дараад нь би тайлбараа бас шаардлагатай бол тодруулж асууна.

Д.Амарбаясгалан: Асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Хариулах хүн байна уу? 8 номерын микрофон, ажлын хэсгийн 8 дугаар микрофоныг өгье.

3.Энхболд: Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Энхболд. Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн оруулсан нэн яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай төслүүдийг санхүүжүүлэх боломж хомс учраас нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээг хэвийн тасралтгүй хангах нэн яаралтай нөхцөл үүссэн шалтгаанаар төрөөс санхүүжилт гаргахгүйгээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийг сонгон шалгаруулалт хэлэлцээ хийнэ, түншлэлийн гэрээ байгуулан ийм шаардлага үүсэж байгаа гэж үзсэн.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагуу төслийг бэлтгэх, сонгон шалгаруулах, зарлах, түншлэлийн гэрээ байгуулах хамгийн багадаа 2-оос 2 жилийн болбол хугацаа зарцуулахаар байгаа. Тийм учраас нэн яаралтай хэрэгжүүлэх шаардлага үүссэн тохиолдолд болбол тухайн энэ хугацааг мөрдөхгүй байх ийм зохицуулалтыг оруулж ирсэн. Энэ яагаад тэгж байгаа вэ гэхээр нийслэл хотын нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээг хэвийн тасралтгүй хангах, нэн яаралтай ийм төслүүдийг болбол ийм энэ аргаар явуулна гэж үзсэн.

Д.Амарбаясгалан: Тодруулга, Сангийн сайд Болдын Жавхлан нэмэлт хариулт.

Б.Жавхлан: Тавантолгой түли компани нийслэл рүү шилжиж байгаатай холбогдуулаад энэ аж ахуйн нэгжийн тэр баланс дээр байгаа бүх л юм дагаад л шилжинэ л дээ. Ашиг ч бай, алдагдал ч бай, хүний нөөц нь, хөрөнгө нь бүгд л дагаад шилжинэ. Тэрнээс биш тэрийг хаашаа нэг газар төсөвт байгууллага руу ч юм уу, төсөв рүү ч юм уу чихдэг тийм төсвийг нэг хогийн сав шиг тэгж харах тийм улсууд гарахгүй байх гэж найдаж байна. Тийм учраас бүх юм нь тэрийгээ дагаад л шилжинэ. Аж ахуйн аргаараа тэндээ тэгээд хоорондоо учраа олно биз.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулга нэг минут.

С.Ганбаатар: Тэгэхлээр нийслэл гэдэг чинь Нямбаатарт л энэ өрийг хувьд нь өгч байгаа биш шүү дээ. Нийслэлийн ард иргэдэд л энэ Тавантолгой түлиний энэ алдаатай 790 тэрбум төгрөгийн хуримтлагдсан алдагдал нэг аравны их наядын санхүүгийн энэ бэрхшээлүүдийг Улаанбаатарчуудад үүрүүлж байна гэсэн үг. Энийг ингээд тодорхой үе шаттайгаар дараа нь яаж зохицуулах вэ гэдгээ ярихгүйгээр зүгээр л ингээд нөгөө бэлчээрээр нь зарна гэдэг шиг ингээд өрөнд оруулж болдог юм уу гэсэн тодруулж асууж байгаа хэлбэр.

2 дугаар зүйл бол тэр түрүүн дутуу л хариулчих шиг боллоо. Миний энэ дээр бол бүүр нарийвчилж тодруулах юм бол урьд өмнө хэрэгжүүлж байгаагүй зарим бүтээн байгуулалтыг ЕРС гэж яриад байх шиг байна. Түлхүүр гардуулах гэрээ гэдгээр ингээд өгчихвөл бүх юм аз жаргалын манлайд хүрчихнэ гэсэн санаа байна. Энэ нь өөрөө зөрчигдөөд, энэ нь өөрөө биелэгдэхгүй болбол ямар хариуцлага, ямар зохицуулалтын механизмууд байгаа вэ гэдгийг л би тодруулж асууж байгаа хэлбэр шүү. Энэ дээр тодруулга авъя.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Ажлын хэсгийн 6 дугаар микрофон Худалдан авах ажиллагааны газрын дарга Батзул.

Ц.Батзул: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Батзул. Том төслүүдийн хувьд ЕРС контракт буюу түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй хийх асуудлаар үндсэндээ том төслийг 3 үе шатад хэрэгжүүлж байгаа. Эхлээд концепт дизайн буюу техник эдийн засгийн нарийвч юу билээ ерөнхий төлөвлөгөө, энэ дээрээ үндэслээд дараагийн шатны инженерингийн тооцоо, тэгээд худалдан авалт, тэгээд барилгын ажил гэсэн гэрээ байгуулж байгаа. Мөн энэ гэрээнд хяналт тавих этгээдийг нь хөндлөнгийн этгээдээр гүйцэтгүүлэх энэ 3 гэрээг энэ Тендерийн хуульд оруулсан нэмэлт зохицуулалтаар хийхээр хуулийн төсөлд тусгасан байгаа. Энэ аргаар хийх худалдан авалтын жагсаалтыг Засгийн газар батална. Тэгэхээс биш бүх тендер шалгаруулалт энэ аргаар явна гэсэн зохицуулалт бол байхгүй.

Д.Амарбаясгалан: Хариулт болсон уу Ганбаатар гишүүн? Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууна.

Б.Энхбаяр: Нэг онигоо байдаг л даа. Сайхан амьдрахад юу саад болж байна вэ гэсэн. Нэг авлигачнаас асуусан чинь Эрүүгийн хууль саад болж байна гэж хариулсан байдаг юм. Хулгай хийхэд нь Эрүүгийн хууль саад болоод байгаа гэж. Энэ төсвийг дагасан Тендерийн хуулийн их том өөрчлөлт орж ирж байгаа. Энэ бол анх удаа орж байгаа биш, өнгөрсөн 4 жилийн хугацаанд 4 дэх удаагаа орж ирж байгаа өөрчлөлт. Энэ өөрчлөлт анх 21 онд Ковидын хуулийг дагаж орж ирж байсан юм. МАН өөрсдөө эрх барьж байсан ч гэсэн энэ хуулийг дэмжихгүй буцааж байсан. 22 онд бас орж ирж байсан юм. Мөн дэмжихгүй буцааж байсан. 2023 онд

Тендерийн хууль шинэчилсэн найруулгаар батлагдахад том төслүүдийг тендергүй хийчихье гэдэг энэ санаархал 3 дахь удаагаа орж ирсэн юм. Энийг Улсын Их Хурал дахь эрх барьж байсан нам өөрөө Бүлгийн олон шударга гишүүд дэмжихгүйгээр буцааж байсан.

Одоо хамтарсан Засгийн газраас 4 дэх удаагаа орж ирж байгаа юм. Энэ бол товчхондоо 40 тэрбум долларын өртөг бүхий томоохон төслийг гэрээ хэлцлийн буюу шуудхан хэлэхэд шууд байгуулах санаархал агуулагдаж байгаа. Хамтрахын нэр нь авлига хулгай гаргах үүд хаалгыг хаахад оршиж байгаа. Ард түмний төлөөллийн дээд байгууллагаар ордог байх ёстой, хянагддаг байх ёстой гэдэг шаардлагыг бид тавьж байгаа.

Гэтэл энэний би ганцхан заалтыг уншъя. Тендерийн хуулийн өөрчлөлтийн 2 дугаар зүйлд 3.3.7-д ийм заалт өгүүлбэр нэмэх гэж байгаа. Засгийн газраас хөгжлийн бодлого шинэчлэлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлээдэх асуудлаар нэр хүнд бүхий тусгай мэдлэг, ур чадвартай зөвлөх хувь хүн, хуулийн этгээдийг сонгох шаардлагатай гэж шийдвэрлэсэн бол Тендерийн хуулийг дагаж мөрдөхгүй гэдэг заалт. Тэгвэл Тендерийн хуулиар яах юм бэ? Тендерийн хуулиа хүчингүй болгочхооч. Тендерийн хуулийг хэрэгжүүлэх асуудал Засгийн газарт хамаарч байгаа. Энэ заалт хэрвээ батлагдвал Улсын Их Хурлаас баталсан Тендерийн хуулийг мөрдөх үү, мөрдөхгүй юу, хэрэглэх үү, хэрэглэхгүй юу гэдгийг Засгийн газар Улсын Их Хурлаас асуухгүйгээр түүгээрээ шийдвэрлэх бүрэн эрхийг олгох гэж байгаа.

Тэгвэл Тендерийн хуулиар яах юм бэ? Хэн дээр, ямар асуудал дээр Тендерийн хуулийг барих эсэхийг Улсын Их Хурлаар орохгүй Засгийн газар түүгээрээ мэдэх юм бол. Тэнд нэг сайд мэдэх юм бол тэгвэл Тендерийн хуулиар яах юм. Тийм учраас энэ асуудал бол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд би халдаж байна гэж үзэж байгаа.

Д.Амарбаясгалан: Үг, Батзул ажлын хэсгийн 6 дугаар микрофон Худалдан авах ажиллагааны газрын дарга Батзул.

Ц.Батзул: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Батзул. Хуульд 2 төрлийн нэмэлт, өөрчлөлт орж байгаа. Эхнийх нь бол Монгол Улсад өмнө нь хэрэгжиж байгаагүй ийм төслүүдийн гүйцэтгэгч нар энэ дэлхийд нэр хүнд бүхий чадавхтай этгээдүүдийг урьж оруулах замаар олон улсад байдаг *selected tender*-н гэдэг ийм аргын дагуу хийхээр хуулийн төсөлд нэмэлтээр оруулж ирж байгаа. Энэ маань нээлттэй тендер шалгаруулалт шиг мөн зарлал нь яваад гэхдээ оролцогчдын зөвхөн урилгад үндэслэн урьж оролцуулна. Уригдсан этгээдүүд оролцох сонирхлоо илэрхийлсэн болбол энэ сонирхлоо илэрхийлсэн этгээдүүдийн дунд тендер шалгаруулалт явуулдаг ийм аргыг нь шинээр оруулж ирж байгаа.

Энхбаяр гишүүний дараагийн дурдсан 3.3.7-д байгаа асуудал дээр яг амьдрал дээр ингээд тулаад харахаар зарим тохиолдолд тусгай мэдлэгтэй этгээд ялангуяа зөвлөх үйлчилгээ хуулийн баг эсвэл томоохон хэлэлцээрийн багийг урьж хамтран ажиллах зайлигүй шаардлага үүсдэг. Жишээ нь стратегийн том ордын хэлэлцээрт оруулах багийг бид нар бол тендер зарлаад гуйж оруулж ирэх боломжгүй байгаад байгаа. Энэ тохиолдолд болбол Арбитрт одоо жишээ нь хуулийн тусгай мэдлэгтэй ийм багийг оруулъя гэх юм болбол тендердэнэ гэхээр нөгөө тал нь хэзээ ч саналаа өгдөггүй тэгээд ингээд гацаа үүсдэг энэ асуудлаас болоод Засгийн газар хэрвээ шийдвэрлэх юм болбол тэр хүмүүсийг урьж, гэрээгээ хийж зөвлөх үйлчилгээ авч болно гэсэн ийм зохицуулалтыг оруулж байгаа юм. Тэгэхээс бүх хүмүүстээ энэ зохицуулалтын хүрээнд шууд гэрээлээд байна гэсэн ойлголт бол биш.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн нэмэлт хариулт өгье. Дараад нь Энхбаяр гишүүн тодруулга.

Ц.Даваасүрэн: Энхбаяр гишүүний хөндөөд байгаа асуудал дээр бас эрх зүйн дүгнэлт гаргах шаардлагатай гэж бид нар үзсэн байгаа. Тухайлбал өмнөх Концессын хуулийн дагуу гэрээ байгуулах гэсэн ийм хуулийн заалт явж байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27.6.1 дээр 1.6 дээр байх, онцгой тохиолдолд бол хуулийг буцааж хэрэглэх гэдэг энэ заалттай нийцэж байгаа эсэх талаар бид нар дүгнэлт гаргах зайлигүй шаардлага бий. Тийм учраас ажлын хэсэг мөн манай Тамгын газрын хууль, эрх зүйн шинжилгээнийхэн энэ яаралтай горимоор хэлэлцэж байгаа учраас энэ хууль, эрх зүйн дүгнэлт гаргах ёстой асуудлууд дээр өнөөдөр ер нь өнөөдрөөс эхлээд яаралтай хугацаанд дүгнэлт гаргах шаардлагууд 3 хууль дээр болбол үүссэн байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Баттөмөрийн Энхбаяр гишүүн тодруулж асууя.

Б.Энхбаяр: Би бол том төслүүдийг хуулийн хүрээнд хэрэгжүүлэхийн төлөө байгаа. Засгийн газрын өргөн барьсан төсөл шиг Улсын Их Хурлаас баталсан хуулийг мөрдөх үү, мөрдөхгүй юү гэдгийг Засгийн газар түүгээрээ шийдэх эрх олгосон замаар шийдвэрлэхийн эсрэг байгаа. Засгийн газар хууль тогтоомжийн үйлчлэлийг зогсоох эрх Засгийн газарт байхгүй.

2 дугаарт хүчингүй болчихсон Концессын хуулийг хэрэглэж гэрээгээ байгуулна гэдэг хууль баталж Улсын Их Хурал болохгүй. Хүчингүй болдоггүй ганцхан хууль байдаг тэр нь Эрүүгийн хууль. Өнөөдөр Монгол Улсад 1986 оны Эрүүгийн хууль ч хүчин төгөлдөр үйлчилж байгаа. Эрх зүйн байдал нь дээр байх юм бол бид хуулийг буцаан хэрэглэх гэдэг зарчим Эрүүгийн хууль дээр л үйлчилдэг. Тэрнээс бус бусад ердийн

хуулиуд дээр тэр тусмаа Концессын хууль хүчингүй болоод жил болчихоод байхад хүчингүй болчихсон хуулиудыг дуртай үедээ хэрэглэнэ, хэрэглэхгүй гэдэг хууль байж таарахгүй.

Д.Амарбаясгалан: Тайлбар хариулт байгаа юу? Алга байна. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуултаа асууя.

М.Энхцэцэг: Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд мега төслүүдийг явуулахад энэ төсөлд энэ хуульд өөрчлөлт оруулахаас аргагүй байна гэдгээр ийм хуулийн өөрчлөлт орж ирж байна гэж ингэж ойлгож байгаа. Тэгээд энэ хуулийн өөрчлөлтийн 10.14 дээрх заалт дээр бас асуулт байна л даа. Тэгэхээр энэ 10.14-ийг ингээд уншаад үзэхээр юу харагдаж байна вэ гээд тэгэхээр ерөнхийдөө цаашидаа төслүүдийг инженерийн тооцоотой нь, ТЭЗҮ-тэй нь, зураг төсөлтэй нь, барилга угсралттай нь, туршилт тохируулгатай нь ингээд бөөнд нь нэг компанид өгдөг ийм юм руу явж байгаа юм байна гэсэн ийм байдал харагдаж байгаа. Эндээс бол тэр мега төсөлд зориулсан юм энэ заалт бол гэдэг юм бол ор тас уншигдахгүй байгаа.

Тийм учраас миний 1 дүгээр асуулт болохоор яг энэ заалтыг мега төсөлд зориулсан юм. Тухайн төсөл маань төсвийн дүн нь тэдээс дээш бол, дээш бол энэ заалтаар явна ч гэдэг юм уу ийм тодорхой болгож өгөхгүй бол та бүхэн мэдэж байгаа Монгол Улсад энэ бүх ажлыг чинь нэгмөсөн бүгдийг нь хийдэг нэг компани бол маш ховор байгаа. Тэгэхээр энэ хуулийн заалтаар бол ер нь цаашидаа бүх л төсөл энэ юугаар явчихаар юм шиг харагдаж байгаа. Тэгэхээр чинь нөгөө маш олон дотоодын компаниуд энэ зах зээлээс арчигдах, зах зээлээс шахагдах ийм үйл ажиллагаа болчих юм шиг ийм харагдаж байгаа.

Тэгэхээр энэ дээр бас хариулт өгнө үү гэж ингэж бодож байна.

2 дугаарт нь болохоор ерөнхийдөө Монголын компаниудын бас хийж чаддаг ажлуудыг хийлгэх тийм боломжоор хангах хэрэгтэй юм биш үү? Өөрөөр хэлбэл Монголын компаниудын дотоодын компаниудын эрх ашгийг давуу байдлыг хангах. Одоо сүүлийн үед хэд бол нэг юм Монголын нөхцөл байдал их харагдаж байгаа. Юу вэ гэхээр Монгол компаниуд хийж чаддаг ажлаа сүүлийн үед бараг авч чадахаа больсон. Бараг 3, 4 тэрбумын ажлыг хүртэл дандаа гаднын компаниуд булаагаад авчихдаг тийм байдал маш их ажиглагдаж байгаа. Энэ бол эсвэл хуулийн цоорхой байна уу, эсвэл гүйцэтгэх энийг хэрэгжүүлж байгаа хүмүүсийн алдаатай дутагдалтай зүйл байна уу? Монгол компаниудаа болохоор бараг үг, үсгийн алдаа хийж байна гээд л хасдаг. Гэтэл гаднын компаниудын санхүүгийн чадавхаа тухайн төслийг санхүүгийн хийх чадвартай гэсэн санхүүгийн чадавхаа тодорхойлсон бичиг баримт нь хуурамч байхад тэрийг шалгаж чаддаггүй шалгаруулаад л цаашиа ажлаа өгөөд явж байгаа.

Тэгэхээр ингээд түлхүүр гардуулах нөхцөлөөр тэр гаднын компаниудыг оруулж ирж байгаа бол тэрний санхүүгийн болон техникийн чадавхыг шалгах, шалгаруулах, шалгаж чадах тэр чадавх чинь манайд өнөөдөр байгаа юм уу?

2 дугаарт болохоор тэр түлхүүр гардуулах нөхцөлөөр гаднын компаниудад ажил өгөхдөө локал контентыг яаж агуулж байгаа юм бэ? Хэдийгээр бид нар хийж чаддаггүй том ажил байлаа ч гэсэн тэр том ажлаас Монгол компаниуд сураад үлдэх ёстой. Тэндээс маш том ноу хау Монгол нутаг дээр үлдэх ёстой. Монголчууд тэр төслийг цаашид нь ашиглалтыг нь аваад явах ёстой. Тийм учраас.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 6 дугаар микрофон Худалдан авах ажиллагааны газрын дарга Батзул.

Ц.Батзул: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Батзул. 10-ын 14 дүгээр зүйл өмнөх Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдах тухай хуульд байсан зохицуулалт. Төрийн хэмнэлтийн хууль болон Төсвийн хууль дээр төсөвтэй уялдуулан энэ зохицуулалт маань хүчингүй болсон. Тэгээд шуурхай хэрэгжүүлэх шаардлагатай томоохон хөгжлийн төслүүдийн яг үнэнээ хэлэхэд одоо бол яг гарчихсан ТЭЗҮ эсвэл ерөнхий төлөвлөгөө эд нар байхгүй. Энийг шуурхай явуулах үүднээс ийм зохицуулалтыг оруулж ирж байгаа.

Үндсэндээ том төслүүд бол 3 үе шаттай хэрэгжинэ. Эхнийх нь бол түрүүн миний хэлсэн ерөнхий ТЭЗҮ-г боловсруулна. Энэ ТЭЗҮ дээр үндэслээд инженерингийн тооцоо, зураг төсөв, барилгын ажлыг нэг хийх ийм гэрээ байгуулагдахаар байгаа. Яг 36²-ыг 1.2-ыг унших юм бол үндсэндээ энэ 3 гэрээ маань хоорондоо уялдаа холбоогүй, харилцан хамааралгүй хүнээр гүйцэтгүүлнэ гэсэн зохицуулалтыг уялдуулан оруулсан байгаа. Барилгын ажлын гүйцэтгэгчдэд нь хяналт тавих этгээд барилгын ажил гүйцэтгэгчээсээ хараат бусаар үйл ажиллагаа явуулна. Мөн концепт дизайн буюу ТЭЗҮ хийсэн этгээд маань ерөнхий ТЭЗҮ хийсэн этгээд маань нөгөө хоёртойгоо харилцан хамааралгүй байхаар хуулиар хориглолт өгсөн байгаа. Тэгэхээр 1 этгээд бүгдийг нь аваад тэр том төслүүдийг нь шууд хэрэгжүүлнэ гэсэн зохицуулалт байхгүй. Үндсэндээ 3-аас доошгүй этгээд энийг 3 хэсэгт хуваан хэрэгжүүлэхээр байгаа.

Д.Амарбаясгалан: Болсон уу хариулт? Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууя. Алга байна. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя. Алга

байна. Жадамбаагийн Баясгалан гишүүн асуултаа асууя. Энэ Улсын Их Хурлын гишүүд намын бүлгүүдээс ирсэн нэрсээрээ асуултаа асуух эрхээ өөрсдөө эдлэх ёстой. Хэрвээ бусад гишүүдийнхээ өмнүүр орж нэрээ өгчхөөд асуулт асуух цаг дээрээ байхгүй байвал энэ бас бусдынхаа эрхэнд халдаж байгаа хэрэг болно шүү. Тэгэхээр нэрсээ өгсөн гишүүд хариуцлагатай, цагтаа байж асуултаа асууж байх ёстой. Цагтаа байж чадахгүй болбол бусдынхаа боломжийг бас ингэж алдагдуулах ёсгүй. Ялангуяа Улсын Их Хурлын шинэ дэг хэрэгжиж эхэлж байгаа. Олон гишүүд үг хэлэх хүсэлтэй байгаа. Тэгэхээр энэ дээр их анхааралтай хандана шүү. Жадамбаагийн Баясгалан гишүүний микрофоныг өгье.

Ж.Баясгалан: Монгол Улсын 2024 оны төсвийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар 4 асуулт байна. Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн тодотголд Монгол Улсын гадаадын зээл тусламжийг 2,2 их наяд төгрөгийн хөрөнгө зарцуулахаар тусгасан байна. Тэгэхээр энэ тусламжтай холбоотойгоор асуухад гадаадын зээл тусламжийн хөрөнгийн хэдэн хувь нь нийгмийн салбарт, хэдэн хувь нь бүтээн байгуулалтын салбарт зарцуулагдахаар байгаа вэ?

2 дугаарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор барих, гадаадын тусламжаар хэрэгжүүлэх гээд тэгээд тэрэн дээр 10 сая төгрөг тавьсан байна лээ. Тэгэхээр энэ жаахан мөнгөөр ямар цогцолбор барих гэж байгаа юм болов уу эсвэл яг яах гэж байгаа талаар ерөөсөө тодорхой мэдээлэл байхгүй байгаа болохоор энийг бас тодруулахыг хүсэж байна.

3 дугаарт нь эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах 5 төсөл арга хэмжээнд нийт 30,3 тэрбум төгрөг төсөвлөсөн байна лээ.

Энэ арга хэмжээнд эмзэг бүлгийн нийт хэчнээн хүнийг хамруулахаар төлөвлөж тооцоолол хийсэн бэ? Энэ талаар тодруулга авах гэсэн юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулах хүн байна уу? Энэ Засгийн газрын ажлын хэсгийнхээ бүрэлдэхүүнийг бүрдүүлээрэй. Нарийн ширийн асуултууд орж ирэхээр хариулах хүн байхгүй гэж өнгөрсөн Баасан гаргийн хуралдаан дээр асуудал үүссэнийг санаж байгаа байх гэж бодож байна. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 7 дугаар микрофон.

Л.Сонор: Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сонор гишүүний асуултад хариулъя. Нийтдээ гадаад зээлийн ашиглалтын хувьд болбол дэд бүтцийн төслүүд нь нийтдээ 77 хувь байгаа. Эдгээр төслүүдийн хувьд болбол зам, тээврийн салбарт 12 хувь нь, усан хангамж эрүүл ахуйн салбарт 11 хувийг, уур уурхайн салбарт 7 хувь нь, хотын хөгжилд 24,9 хувь, эрүүл мэндийн чиглэлээр бол 7,8 хувь, эрчим хүчний чиглэлээр 24 хувь, боомт, худалдаа, эдийн засгийн чиглэлээр 0,9 хувь, нийгмийн болон бусад чиглэлээр 11 хувь гэсэн задаргаатай хэрэгжиж байгаа гадаад зээлийн ашиглалт бол.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Сая манайхаас өгсөн тоо болбол Баясгалан гишүүнээ юу шүү энэ 2024 оны нийт бүтэн жилийн тоо шүү. Энэ тодотголтой бол хамаатай тоо биш шүү. Тийм. Тодотголынх болбол арай өөр байдлаар орж ирж байгаа. Тэр эмзэг бүлгийнх ч бас л уг нь энэ оны л төсөв дөө, тодотгол дээр байхгүй л тоо асуучихлаа даа. Аль манайхаас хэн Дэлгэржаргал хаана байгаа юм бэ? Зүгээр саяын тэр тоог 24 оны төсөв дээрээс асуугаад байна шүү дээ тэрийг хэлээч.

Д.Амарбаясгалан: Баясгалан гишүүн уншаад өгөх юм уу?

Б.Жавхлан: Үгүй ээ энэ.

Д.Амарбаясгалан: Санжаадорж ажлын хэсгийн 3 дугаар микрофон хариулт өгье.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж Баясгалан гишүүний асуултад хариулъя. Төсвийн тодотголоор болбол гадаад зээлийн ашиглалттайгаар холбоотойгоор бол 984 тэрбум төгрөгөөр бол нэмэгдүүлэхээр болбол төсвийн төсөлд бол тусаж орж ирсэн байгаа. Түрүүний Сонор даргын хэлдэг бол бүтэн жилээрээ 2,2 их наядаараа бол байгаа. Тодотголыг дангаар нь ярих юм болбол нийтдээ бол 11 төсөл байгаа. Энэ 11 төслөөс 8 төсөл нь болбол дэд бүтэц, эрчим хүч, орон сууцтай холбоотой төслүүд байгаад байгаа юм. Тухайлан хэлэх юм бол Эрдэнэбүрэн усан цахилгаан станц, мөн Улаанбаатар хоттой холбоотойгоор бол цэвэрлэх байгууламж, Солонго 1, 2 төсөл, Улаанбаатар-Дархан чиглэлийн зам, Улаанбаатар хотын ногоон сууц барих төсөл, Улаанбаатар хотын гэр хорооллын хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл гэсэн ийм төслүүд байгаа. Дээр нь мөн Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл байгаа. Мөн 10 аймгийн дулааны станц. Ингээд болбол дэд бүтцийн төслүүд бол нэмэгдэж орж ирж байгаа. Дээр нь аж үйлдвэртэй холбоотойгоор бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя, ажлын хэсгийн микрофон.

М.Санжаадорж: Дээр нь нэмж хэлэх юм бол газрын тосны үйлдвэр барих төсөл бол орж ирж байгаа. Энэхүү төсөл маань болбол 2017-гоос 27 оны хооронд хэрэгжихээр ийм төсөл байгаа. Энэ төслөөс гадна нийгмийн үйлчилгээний талаар болбол бас 2 төсөл

орж ирж байгаа. Энэ болбол эрүүл мэндийн чиглэлтэй бол 1 төсөл орж ирж байгаа. Мөн Зээлийн батлан даалтын сантай холбоотойгоор бас 1 төсөл орж ирж байгаа. Ингээд нийгмийн чиглэлээр 2 төсөл орж ирж байгаа гэсэн үг. Яг мөнгөн дүнгээр нь хэлэх юм бол нийгмийн чиглэлтэй төслүүдийнх нь тоо бол 72,5 тэрбум төгрөгөөр бол ашиглалт болбол сайжирна гэсэн ийм тооцоотойгоор, харин дэд бүтцийн салбар бол 858,6 тэрбум төгрөг, тэгээд аж үйлдвэрийн чиглэлээр болбол нөгөө газрын тос боловсруулах үйлдвэр маань бол 52,7 тэрбум төгрөг гэсэн ийм байдалтайгаар задарч бол орж ирж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Гонгорын Дамдинням гишүүн асуултаа асууя. Мөн алга байна. Бадрахын Найдалаа гишүүн асуултаа асууя.

Б.Найдалаа: 2 товчхон асуулт байна. Нэг нь Засгийн газрын үйл ажиллагаа хөтөлбөр дээр нэг чухал төсөл байхгүй байна. Нэлээн олон жил ярьсан Уур амьсгалын ногоон сангаас Монгол Улс олон яам олон Засгийн газар дамжиж дамжин дамжин хийгээд Ногоон санхүүгийн корпорац байгуулах тухай нэг ийм төсөл батлуулсан юм. Монгол Улс анх удаагаа зээл биш өөрийн хөрөнгөд хөрөнгө оруулах тийм шийдвэр гаргуулсан. Тэгээд нийт 28 сая долларын хөнгөлөлттэй зээл маш бага, дээр нь 2 сая долларын буцалтгүй тусламж санагдаж байна. Энэ үйл ажиллагааны хөтөлбөрт байхгүй байх юм. 24 оны төсөлд төсөвт байгаа гэж ойлгосон. Тэгээд энэ ингээд төсөвт нь байхгүй, үгүй ээ төсөвт нь байгаа, хөтөлбөрт ороогүй байгааг би жоохон гайхаад байна л даа. Энэ тэгээд яг байгаа юу, байхгүй юу? Тодотголд орсон уу, ороогүй юу, энэ төсөл явах уу, явахгүй юу? Ямар бодлоготой байгаа вэ?

2 дахь нь энэ тендертэй холбоотой 31.5 дээр тендер шалгаруулалтыг тухайн аргаар 2-оос доошгүй удаа зарлахад нэг ч тендер

ирээгүй бол төрийн болон орон нутгийн өмчит, эсвэл өмчийн оролцоотой, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээр тухайн худалдан авах бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгүүлж болно гэж байгаа юм. Энэ зүйлийг бол ойлгохгүй байна. Хэрвээ хувийн хэвшилээс санал байхгүй болбол ТӨК ашигтай ч байсан, ашиггүй ч байсан юу ч хамаагүй яаж ийгээд хийнэ гэсэн зарчим үнэртээд байгаа байхгүй юу. Энэ болбол нөгөө бид нарын яриад байдаг ТӨК-ийн засаглалыг сайжруулъя, ашгийн төлөө байх ёстой, менежментийг нь шинэчилъе, засаглалыг сайжруулъя гэдэгтэй 180 градус зөрж байна. Тэгээд энэ ямар зарчим, хаана байдаг зарчим энд орсон бэ? Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Хөтөлбөртэй холбоотой асуудлыг ажлын хэсэг дээр юм уу эсвэл хөтөлбөртэй холбоотой асуудал орж ирэхэд тодруулах нь зөв байх. Тэр Төрийн худалдан авах ажиллагааны тухай хууль дээр орж байгаа тэр өөрчлөлт болбол хувийн хэвшилтэй огт өрсөлдөж байгаа зүйл огт биш шүү. Бид нэг тийм хоосон зарим нэг лоозонгоос нэг хэтэрхий хоосон юм болгоод хэт нэг тал руу нь бас туйлирдуулчихмааргүй байгаа юм. Энэ төсөв гэдэг чинь энэ төсвийн орон зай 1 төгрөг болгон маш үнэтэй байдаг, маш үнэтэй байдаг. Тийм учраас бид ингээд жил жил шинэ хуучин, гадаадын зээл тусламжаар гээд л 2 их наяд гаруй, ингээд зарим жил бол 3 их наяд хүрч байгаа. Тэгэхээр энэ бүгдийг маш сайн гүйцэтгэлтэй байлгах нь л энэ төсвийн үр дүн юм байгаа юм. Найдалаа гишүүнээ.

Тэгээд энийг чинь тэр болгон ААН-үүд бас дийлэхгүй, орохоор төсөвт өртөг нь бага учраас алдагдалтай гарах гээд эрсдэлтэй гарах гээд, одоо ингээд л Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сум дээр тэнд нэг цэцэрлэг гэхэд л тийшээ оччихдог ААН байхгүй, тендер нь хэд ч

зарлагдав даа. Тэгэхээр ийм зүйлүүд дээр орон нутгийн болон ТӨК-уд эдийн засгийн нэг их өндөр ашиггүй тэг ашигтай байгаад ямар ч байсан ажилчдынхаа цалинг тавиад ингээд явчхаж болох юм байна гээд өөрсдөө үзээд орж байгаа тохиолдолд шүү дээ. Тэрнээс биш хүчээр тийш нь тууж аваачаад ингээд тулгаж байгаад ингээд оруулчхаж байгаа зүйл огт биш. Энэний цаана нэгэнт орон зайг нь эзлээд төсөвлөгдчихсэн нэг төгрөг болгоныг үр дүн өгсөн, бүтээн байгуулалт өгсөн төрийн үйлчилгээг явуулахад цаашаага яг зорилгоо биелүүлэх ийм ажил болгож л бид хэвшмээр байгаа юм. Энэний төлөө хийж байгаа зүйл байхгүй юу. Энэ чинь тэгээд оруулсан төсөвлөсөн 100 хувь хөрөнгө оруулалтын маш бага хувьд нь, маш бага хувьд нь ер нь 5 хүрэхгүй л шахуу л ийм л хувь байдаг юм.

Тэгэхээр энэ ажил болбол бас их үр дүнтэй болно гэж ингэж харж байгаа. Энийг энэ дээр Нямбаатар дарга Улаанбаатар хот дээр болж байгаа хэд хэдэн жишээнүүдийг хэлдэг. Нэг жишжигхэн дэд бүтцийн чиглэлийн тендер зарлахад аж ахуйн, хувийн аж ахуйн нэгжүүд орж ирдэггүй. Гэтэл нийслэлийн өөрийнх нь тусгай зөвшөөрөлтэй компаниуд нь хийчихээр юмыг ингээд бас хийх боломжгүй байх жишээтэй хуулиараа. Тэгээд тийм болохоор энэ бүгдийг л нэг төгрөгийг ч агаарт цацаж үлдээлгүй ажил болгохын төлөө л хийж байгаа зүйл байхгүй юу.

Тэгээд 2 удаа орж ирээгүй ийм зарласан тендер гэдэг чинь цаана нь юм хэлээд байна шүү дээ. Ямар ч ААН-үүд орохгүй нь. 2 удаа зарлана гэдэг бол аль хэдийн хагас жил болчхож байгаа юм. Тийм учраас бид энийг ингэж оруулж ирж байгаа юм. Энийг тэгээд ойлгож дэмжиж өгнө биз. Тэрнээс биш хувийн ААН-үүд орчихсон ийм зүйл дээр төрийн компани орж ирээд ажил нь булаацалдаж байгаа асуудал бол ерөөсөө огт биш шүү. Тийм.

Д.Амарбаясгалан: Бадрахын Найдалаа гишүүн тодруулга.

Б.Найдалаа: Энэ зүгээр би зарчим ярьж байгаа юм л даа. Хэрвээ ингээд явах юм болбол төрийн өмчит, орон нутгийн өмчит компани улам олирох хандлага үүсэх байхгүй юу. Өөрсдөө л хийчихсэн нь дээр шүү дээ. Тэгээд тендер нь буруу байна гэсэн үг биз дээ энэ чинь. Тэгээд энэ дээрээ анхаараад энэ бүтцийг нь, зарчмыг нь өөрчлөхгүй болбол улам л олироод байна. Улам л компаниуд бий болоод байна. Ашиггүй ч гэсэн хийчихье төрийн төлөө хийчихье гэсэн маягаар орон нутгийн өмчит компани олишно. Тэгэхээр энэ болбол зарчим нь буруу гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Дав.Цогтбаатар: Баярлалаа. Өдрийн мэнд. Хөтөлбөртэй холбоотойгоор 2, 3 асуудал байна. Тэгээд энэ бодлоготой холбоотой бас 1 асуудал байгаа. Бодлоготой холбоотойг нь түрүүлээд асуухад ноосон бордооны үйлдвэр, эцсийн бүтээгдэхүүн малын гаралтай түүхий эдээр эцсийн бүтээгдэхүүн барьж байгуулна гээд Ардын намын мөрийн хөтөлбөрт ч байсан, манай намын мөрийн хөтөлбөрт ч байгаа. Энэ хөтөлбөр дээрээ бас тухайлсан нэрээрээ байхгүй алга болчихсон. Хөдөө аж ахуйн сайдын танилцуулж байгаагаар Цагаан алт хөтөлбөрт оруулчихсан гээд байгаа. Цагаан алт хөтөлбөрийг нь харахаар яг бас тухайлж бичсэн зүйл байхгүй байна лээ.

Тэгээд энэ ноосон бордооны үйлдвэр чинь өөрөө малчид руугаа чиглэсэн бодлого л гэж би бол хараад байгаа юм. Монголыг эзэнтэй байлгах, малтай байлгах гэдэг чинь орон нутаг энэ Монгол чинь өөрөө хот улс биш шүү дээ. Бүхэл бүтэн улс. 1,5 сая км квадрат газар нутагтай ийм орон. Тэгж байтал энэ малчид руугаа чиглэсэн нэг ч бодлого,

нэг ч үйлдвэр ноосонд нь чиглэсэн ядахдаа бид нар нэг үйлдвэр барьж чадахгүй гэдэг ийм асуудал яриад сууж байгаа юм.

Тэгээд яг нөгөө нэг энэ хөтөлбөрүүдийг задлаад харахаар жишээлэхэд энэ Дарханы замтай холбоотой асуудал байгаа. Ажлын гүйцэтгэл 94 хувьтай, зээлийн ашиглалт нь 54 хувьтай, одоо тэгээд тодотголоор дахиад 131 тэрбумыг авна гэж байгаа юм. Энэ зээлийн ашиглалтаа сайжруулаад зам нь баригдаад тэртээ тэргүй дуусчихсан юм чинь зээлийн ашиглалтаа сайжруулаад, төсвийн тодотгол хийхгүйгээр явчхаж болдоггүй юм болов уу?

Тэгээд дахиад энэ 10 аймгийн дулааны станцын асуудал байгаа. Өвөрхангай, Баянхонгор. Өвөрхангай дээр Хосоо гишүүн бид 2 яг газар дээр нь ажилласан. Хэн ч байхгүй. Тэгээд энэ дээр яг нөгөө 38,8 тэрбумыг тодотголоор тусгачихсан. Нийт төсөвт өртөг нь 148,7 сая, гүйцэтгэл нь 45 хувь, зээлийн ашиглалт нь бас 40 хувь. Дахиад тодотгол хийнэ 38, сайн явж байгаа энэ гэсэн. Тэгээд сайн явж байгаа мэдээллүүдээ бас Сангийн яам өгье гэсэн өгөөгүй байгаа.

Тэгээд энэ нөгөө аудитын дүгнэлт дээр бас тодорхойгүй төсөл, арга хэмжээний багцын задаргааг тодорхой болгох шаардлагатай гэгчихсэн байгаа. Эд нар нь хэзээ тодорхой болж орж ирэх юм бол?

Тэгээд энэ нөгөө тодотгосон орлоготой холбоотойгоор энэ нүүрсний орлогын гүйцэтгэл болбол бараг 60 хувьтай явж байна гэж ойлгосон. Гэтэл бид нар энэ Үндэсний баялгийн санд хуримтлуулах ёстой мөнгө чинь бас өөрөө багасаж орж ирээд байгааг бас ойлгохгүй байгаа. Энэ дээр бас нэг тайлбар өгөөч гэж хэлэх гэсэн юм.

Тэгээд энэ Их Хурлын даргад бас хандаж хэлэхэд энэ аудитын зөвлөмж, дүгнэлт гараад байгаа энэ дүгнэлт дээр жишээлэхэд бүрэлдэхүүнд нь Үндэсний аудитын газрын дарга өөрөө байхгүй. Яг ингээд орлогч аудит эсвэл дэд дарга нар нь аудитад дүгнэлт хийгээд, өөрөө тоо боддог, боддоггүйг нь мэдэхгүй. Энэ чинь бид нар төсвийн улсын асуудал яриад байгаа байхгүй юу. Тэгээд үнэхээр энэ аудитын дарга өөрөө ажлаа хийдэггүй юм бол чаддаг болохгүй болбол бүүр АН-даа өгчих. Бид нар хүн томилоод яг энэ төсөв дээр хяналт шалгалт хийгээд явъя гэдэг ийм бас нэг санал гаргаж байгаа юм. Болсон, баярлалаа.

Д.Амарбаясгалан: Аудитын байгууллага болбол Улсын Их Хурлын нэрийн өмнөөс шийдвэрийн хяналт хэрэгжилтэд анхаарал тавьж ажилладаг. Тэгэхээр нам энд болбол хамаагүй гэдгийг их сайн ойлгох ёстой, төрийн байгууллага. Хариулья. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Цогтбаатар гишүүний асуултад хариулья. Тэр ногоон бордоо болон нөгөө цагаан алттай холбоотой ялангуяа хөнгөн аж үйлдвэрийн энэ төслүүдийг бүгдээрээ 25 оны төсөв ярих үед илүү дэлгэрэнгүй ярих болов уу гэж найдаж байна. Бидний хувьд бас судлах ёстой. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам маань өөрөө энэ дээр ямар бодлоготой байх нь уу, Засгийн газар дээр хараахан бас их нарийвчилж яригдаагүй байгаа асуудал шүү.

Дарханы зээлийн ашиглалт ер нь болбол төр энэ нэг хэдэн ААН-үүдийг зовоогоод байгаа л гэсэн үг. Мөнгийг чинь өгнө, өгнө гээд, тэгээд яах вэ төсвийнхөө боломжийнхоо хэмжээгээр төсөв дээрээ тавиад л өгдөг, гүйцэтгэлүүд нь гарчихсан, санхүүжилт нь хоцроод байгаа л ийм зүйл. Энэ удаагийн төсвийн тодотголоор оруулж ирж байгаа гол том нөгөө хөөрөлдөөд байгаа асуудал чинь энэ шүү дээ. Нэгэнт зээлийг нь авна

гээд Их Хурал дээр шийдчихсэн Засгийн газар та нар ав, энийгээ хэрэглэ гээд. Тэгээд тэрнийх нь дагуу хэрэглээд эхэлчихсэн. Гүйцэтгэл нь аягүй сайн гарчихсан. Одоо энэ гүйцэтгэлийг нь сайн гарчихсан юм чинь хэдүүлээ зээл ашиглалтыг Засгийн газар энийгээ нэмээд, санхүүжилтийг нь өгье гэж байгаа л асуудал юм байгаа юм. Үндсэндээ ажлууд нь болбол ер нь дуусаж байгаа, гүйцэтгэлүүд нь маш өндөр гарчихсан, тэгээд үлдсэн зээлийнхээ санхүүжилтээ авч байгаа л ийм асуудал байгаа. Энэ чинь 5 хэсэг дээр 5 ААН, бараг 6 ААН-д ингэж хуваагдаж очихоор ийм санхүүжилт байгаа.

10 аймаг дээр манайхан яагаарай, тэр аль аль аймаг сайн явж байгаа билээ. Тэгээд таны хэлсэн дурдсан аймаг бол муу явж байгаа аймаг шүү тийм, тэрэн дээр бараг гүйцэтгэл гарахгүй байх. Ер нь зарим орон нутаг, ер нь орон нутгаас өөрсдөөс нь шалтгаалж байгаа их зүйлүүд байгаа. Тэр дэд бүтцүүд нь өмнө нь жишээ нь хувьчлагдчихсан, тэгээд шугамаа өгөхгүй байгаа, тэрийг нь шинэчлэх гээд ингээд хамаг ажил нь зогсчихсон бүүр 5 жил болоход ажлаа эхлүүлж чадаагүй аймаг байгаа шүү дээ бүүр. Тэр багцын задаргааг хэлээдхээрэй. Үндэсний баялгийн сан буураагүй, 20 хувиар бүүр нэмэгдэж орж ирж байгаа. Манайхан тэр тоон мэдээллүүдээ өгчих дөө.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал. 10 аймгийн дулааны станцын төсөл маань Солонгосын Эксим банкаар 2020 онд эхэлсэн. Нийтдээ 10 аймагт хэрэгжиж байгаа. Одоогоор гэрээ байгуулаагүй нэг аймаг Архангай аймаг байгаа. Төсвийн тодотгол дээр зээлийн байгуулсан гэрээнийхээ ашиглалтыг нэмэгдүүлэх 38,8 тэрбум, энэ маань явж

байгаа төслүүд байгаа Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр аймгуудын хувьд бол гүйцэтгэл сайн явж байгаа. Тийм учраас яг ирсэн гүйцэтгэл дээр нь үндэслээд бид нар ашиглалтыг нэмэгдүүлэхээр тусгасан. Өвөрхангай аймгийн хувьд бол 46 хувьтай явж байна.

Д.Амарбаясгалан: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбаагийн Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ Улсын Их Хурлын 63 дугаар тогтоол гараад Цагаан алт үндэсний хөтөлбөрийг баталсан. Энэ хөтөлбөрийн гол зорилго бол малын гаралтай түүхий эдээ инновац шингээсэн эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэх, экспортлох бодлогыг дэмжихээр заасан байгаа. Энэ хүрээнд бүхий л арьс шир, ноос ноолуур, энэ хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрүүдийн асуудал орно. Тэгэхээр тухайлан нэг түүхий эдийг барьж аваад томъёолоогүй, нийтэд нь Цагаан алт үндэсний хөдөлгөөн батлагдсан тул энэ хүрээнд асуудлыг шийднэ.

Гэхдээ яаж шийдэх вэ гэдэг дээр энэ төсвийн тодотгол дээр 23,5 тэрбум төгрөгийн хүүгийн татаас суусан байгаа. Тэгэхээр энэ салбарын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд төсөл хөтөлбөрөө бэлдээд, арилжааны банкнууддаа хандана. Төрийн оролцоо зөвхөн хөнгөлөлттэй зээлийн шугамаар дэмжих бөгөөд тэр хүүгийн зөрүүг төсөвт сууж суулгаж өгч байгаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Цогтбаатар гишүүн хариултаа авсан уу? Очирбатын Амгаланбаатар гишүүн асуулт асууя.

О.Амгаланбаатар: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Би бас нэг юм асууя. Энэ чадавхад суурилсан хэлэлцээрийн аргыг нэвтрүүлэх гээд ингээд байж байна. Тэгээд энэ яг сүүлийн 5 жилийн

хугацаанд энэ маргаанаас болоод хэдэн ажил яг хийгдээгүй байгаа вэ? Монгол Улсын хэмжээгээр яг ямар үнийн дүнтэй хэдэн ажил энэ шүүхийн маргаанаас болоод хийгдээгүй байгаа гэдэг энэ зүйлийг бас энэ гишүүдэд мэдээллийг нь өгсөн нь дээр байх гэж би бас ингэж бодож байна.

Яг ингээд аймаг орон нутагт ажил хийгээд явж байхад энэ бас энэ Монгол Улсад бүтээн байгуулалтын хугацаа маш богино хэдхэн сар байдаг. Тэр хооронд ингээд нэг тендер зарлагдаад, улсын төсөв батлагдаад, аймгийн төсөв батлагдаад, ингээд тендер бичиг баримт бүрдүүлэх тендер гэж явсаар байгаад бас л ингээд л нэг л шүүхийн маргаан үүсчих юм болбол тэгээд л тэр ажил явахгүй жил дамжаад явчихдаг. Тэгэхээр бас энийг нэг арай бас тоо судалгааг нь маш ийм тэдэн ажил тийм үнийн дүнтэй Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилд гэж хэлээд ингэж гаргаж ирээд ингээд танилцуулаад, энэ дээрээ дүгнэлт хийгээд, хэрвээ энэ үнэхээрийн дорвитой хэмжээний, том хэмжээний мөнгөн дүнтэй олон арга хэмжээ энэ шүүхийн маргаантай асуудлаас болоод урагшаа энэ ажил маань яваагүй болбол энэ өөрчлөлтийг оруулсан нь дээр байх.

Хэрвээ үнэхээр энэ нь болбол нэг их тийм том өөрчлөлт биш буюу маш цөөн арга хэмжээ дээр нь үнийн дүн нь ийм бага байх юм болбол заавал энийг бол оруулах нь шаардлагагүй юм гэж ингэж бодож байна. Тэгэхээр энэ талаар нэг энэ холбогдох байгууллага Сангийн яам нэг мэдээлэл өгөөч гэж хэлэх байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 8 дугаар микрофон.

3.Энхболд: Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Энхболд Амгаланбаатар гишүүний асуултад хариулъя. Яг гомдол маргаан шүүх дээр гомдол маргаан гарснаас шалтгаалаад ажил нь зогссон тоо хэмжээг бол танд

тусад нь ажлын шугамаар гаргаж өгье. Харин сүүлийн 5 жилийн хугацаанд Сангийн яаман дээр гарч байгаа гомдлын тоог болбол танилцуулъя. 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээн дээр нийтдээ 17 хувьд нь болбол гомдол гарч байсан. 20 онд болбол 8 хувьд нь гомдол гарсан, 21 онд 4 хувьд гомдол гарсан, 22 онд 12 хувьд нь бол гомдол гарсан, 23 онд 2 хувьд нь гомдол гарсан, 24 онд одоогоор 5-аас 6 хувьтай ийм гомдол Сангийн яаман дээр гомдол маргаан хянан шийдвэрлэгдээд явж байна.

Д.Амарбаясгалан: Очирбатын Амгаланбаатар гишүүн тодруулга.

О.Амгаланбаатар: Тэгэхээр ер нь бол жилээс жилд хувь нь буураад, энэ жилийн хувьд болбол өчүүхэн бага хувьтай байна шүү дээ тийм ээ. Тэгэхээр заавал энэ шууд гэрээ байгуулах асуудлыг болбол боливол зүгээр юм байна. Энэ хуулиа бол энэ заалтыг болбол больсон нь дээр юм байна. Тэгэхгүй болбол одоо энэний чинь энийг оруулж ирж байгаа гол зорилго нь үнэхээрийн энэ шүүхийн маргаан буюу энэ асуудлаас болоод ажил, арга хэмжээ энэ дулааны улиралд багтахгүй байна гэдэг ийм асуудлаар зорилгоор энэ асуудал орж ирж байгаа гэж ойлгож байгаа.

Гэтэл энэ Сангийн яамны саяын энэ хариулж байгаагаар болбол жилээс жилд багассаар байгаад одоо болбол маш бага хувийг эзэлж байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр энэ заалт болбол шаардлагагүй юм гэдэг нь яг энэ хариултаас ингээд харагдаж байгаа юм. Тэгэхээр энийгээ бол аваад, шударга зарчмаар нь тэр өрсөлдөөд, Тендерийнхээ хуулийн дагуу 2 удаа явдгаараа яваад, тэгээд ингээд явсан явсан нь зөв юм байна гэдэг нь бол эндээс харагдаж байна гэж хэлэх байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 8 дугаар микрофон.

3.Энхболд: Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Энхболд. Гишүүний саяын ярьсан арга болбол Засгийн газрын тогтоолоор батлагдсан одоо энэ төсвийн тодотгол хөтөлбөр дээр орж ирж байгаа томоохон төслүүдийн хүрээнд л хэрэгжих ийм арга байгаа юм. Түүнээс биш болбол нийтлэг бусад худалдан авалтууд болбол нээлттэй тендер шалгаруулалтынхаа журмаар явна. Энэ томоохон төслүүд нь болбол дотоодод хийж хэрэгжүүлэх тийм чадамж багатай гэж үзсэн тохиолдолд болбол олон улсад нэр хүнд бүхий тухайн чиглэлээр мэргэшсэн ийм компанийг урьж оролцуулах ийм нэг арга юм.

Д.Амарбаясгалан: Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууя. Байхгүй байна. Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Энэ төсвийн тодотголыг дагалдаад 10 гаруй хуулийн төсөл, 2 ч Их Хурлын тогтоолын төсөл орж ирж байна. Тэгэхээр Хууль тогтоомжийн тухай хуулиараа бол аливаа хуулийн төслийг бол бас шат дараатай хэлэлцүүлгүүд явах ёстой байдаг. Гэтэл сүүлийн жилүүдэд бол Засгийн газрын зүгээс энэ төсөв дагалдуулаад ч гэдэг юм юм уу тийм ээ ийм маягаар хуулийн төслүүдийг ингэж яаралтай горимоор оруулж ирээд шууд алх цохиулах ийм арга барилтай болчихсон байж байдаг. Тэгээд уг нь бол Хууль тогтоомжийн тухай хуулиараа бол эдгээр хуулийн төслүүд дээр бол нэлээн дэлгэрэнгүй хэлэлцүүлэг өрнөөд явбал 1 дүгээрт сайн байна гэж хэлэх байна.

Тэгээд 2 дугаарт энэ хамтарсан Засгийн газар эдийн засгийн реформ хийх гэж байгуулагдсан гэж ойлгож байгаа. Бизнесийн орчныг сайжруулах гэж байгуулагдсан, шударга ёсыг тогтоох гэж байгуулагдсан гэж ойлгож байгаа. Тэгэхээр анхныхаа оруулж ирж байгаа томоохон тийм арга хэмжээний

хөтөлбөртэйгөө хамт, төсвийн тодотголтойгоо хамт дагалдаад энэ бизнесийн орчинтой маш нягт холбоотой хэд хэдэн хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтийг ийм хулгайн гэх маягийн аргаар оруулаад ирж байгаа нь бол бас харамсалтай санагдаж байна. Тухайлбал төрийн худалдан авах ажиллагаа энэ Төр, хувийн хэвшилийн түншлэлийн тухай хууль зэрэг энэ хууль тогтоомжууд дээр чинь бид нар реформ хийх гээд байгаа юм биш үү?

Гэтэл жишээлбэл энэ төрийн худалдан авах ажиллагаа дээр холбоотой саяын дурдагдаад байгаа чадавхад суурилсан хэлэлцээ гэдэг нь ерөнхийдөө ямар ч сонгон шалгаруулалтгүйгээр засаг өөрийнхөө үзэмжээр ийм гэрээ байгуулах эрхийг Засгийн газарт олгоод байгаа ийм зүйл. Тэгэхээр бид бол энэ төсвийг ил тод, нээлттэй болгохыг хүсээд байгаа. Тэгэхээр энэ хуулийн төслүүдээ бас татаж аваач гэж Засгийн газарт бас хичээлгүүлэн захих байна.

Тэгээд энэ ажлын хэсгийнхэн болохоор үүнийгээ зөвтгөж байгаа арга нь ийм дотоодын аж ахуйн нэгжийн чадамж хүрэхгүй, дэлхийд нэр хүнд бүхий ийм этгээдүүдэд л урилга өгнө гэж яриад байгаа юм. Тэгэхээр энэ төсвийн тодотголд орж ирж байгаа энэ 3 гаруй их наяд төгрөг, ер нь энэ 24 оны төсөв дээр нийт худалдан авалтын хэдэн хувь нь дотоодын аж ахуйн нэгжид олгогдож байгаа вэ? Тухайлбал энэ 3,1 их наяд төгрөгийн зарлага дээр дотоодын ААН-үүдээс худалдан авалт хийх, дотоодын ААН-үүдтэй гэрээ байгуулах тэр төсөл хөтөлбөрүүд нь хэдэн хувийг эзэлж байгаа вэ гэж асуумаар байна. Яагаад вэ гэхээр бид төсвөө тэлж болно. Тэгээд энэ төсвийн энэ зарлага чинь бол бас эргээд дотоодынхоо эдийн засгийг тэтгэж баймаар байна. Тэгэхгүй тэгээд л дотоодын ААН-үүдийн чадамж нь хүрэхгүй байна, тэгээд л гаднынхангай гэрээ байгуулна гэж яриад байх юм нэг. Тэгэхээр Сангийн яамнаас энийг асууя.

Дээрээс нь энэ ХҮН намын төлөөлөл Доржханд сайд бол энэ төрийн худалдан авах ажиллагааг ил тод нээлттэй болгоно, илүү сайжруулна гээд байсан. Тэгээд энэ худалдан авах ажиллагаатай холбоотой тусдаа ийм бие даасан ийм багц хууль орж ирэх юм уу ойрын хугацаанд? Тэрийг энэ засгийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Гишүүн маань оруулж ирж байгаа төсвийн тодотголоо сайн уншиж, танилцаж амжаагүй л байгаа юм шиг байна. Жишээ нь 3 их наядын чинь тэр 984 тэрбум төгрөг гадаад зээлийн ашиглалт гэдэг маань аль хэдийн сонгон шалгаруулалт нь явагдчихсан, төслүүд нь бараг дуусаж байгаа, тэгээд мөнгөө авч чадахгүй байгаа, үнэхээрийн нөгөө төр тэд нарыг аргалж байгаад бүр хохироочихсон тэр юмаа л нөхөж төлөх гээд байгаа байхгүй юу.

Нийслэлийн тэр 500 тэрбумыг эхэлж гаргасан бонд тэр Бөөрөлжүүтийн цахилгаан станцын энэ эхний блок 150-ийг ашиглалтад оруулахаар тийшээ дамжуулан зээл байна. Намар ингээд ашиглалтад ороод, энэ өвлийг нийслэлчүүд маань давж гарах гээд иймэрхүү бэлтгэл ажлууд хийгдэж байгаа.

Шинээр хийгдэх сонгон шалгаруулалт нь болбол худалдан авах ажиллагаа болбол тэр 484 тэрбум төгрөг гээд ТЭЗҮ, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний нөгөө томоохон 6 төсөл дээр хийгдэх ажлууд бол байгаа. Энэ дээр харин ёстой гадаадынхан орж ирэх нь үү, дотоодынхон орж ирэх нь үү ёстой бүгдээрээ л нээлттэй, ил тод хамтдаа харцгаах болов уу гэж ингэж бодож байна.

Тэр Төрийн худалдан авах ажиллагааны тухай хууль дээр яах вэ шинэ юм болгон л ийм хардалт төрүүлдэг л дээ, үгүйсгэх арга байхгүй. Тэгэхдээ ямар ч байсан хэдүүлээ энэ Засгийн газраа хамтарсан Засгийн газрыгаа байгуулчихсан, нэг дэмжээд нэг талаараа дэмжээд байгаа юм шиг нөгөө талаараа бас хойш нь татаад баймааргүй байгаа юм. Нэг ингээд дэмжиж өгөөд явуулаад ингээд харах үзэх хэрэгтэй. Үр дүнг нь нэхэх ёстой гэж ингэж харж байна. Тийм ч учраас томоохон зорилтууд ингээд тавиад явлаа. Тэр 2 томоохон тэр бүтээн байгуулалтуудынхаа жагсаалтыг гаргахдаа оруулж ирж байгаа хувилбар дээр бол Засгийн газраас жагсаалт гаргана гэгчихсэн байгаа. Гишүүд санал хэлэхдээ энийг Их Хурлаар оруулчихвал яадаг юм бэ гэж байгаа юм. Тэр их харин зөв санал яваад байгаа юм. Тэгэхээр ерөөсөө яг энэ, энэ төслүүд дээр энэ төрийн худалдан авах ажиллагааны энэ аргыг, энэ шинэ аргаа хэрэглэж болно. Бусад дээр нь болохгүй шүү гээд тэгээд тогтоочихвол бүр их амар болох гээд байгаа юм. Тэр саналыг харин одоо ажлын хэсэг байгуулаад хэлэлцэх шатандаа энэ санал гарч ирвэл энэ дээр бол харин нээлттэй баймаар байгаа юм.

Тэгэхгүй болбол манайх хуучнаараа болбол тэгээд л нэг маргаан үүсээд л болбол тэгээд л 1 жил алдана, 2 жил алдана. Ерөөсөө 3-хан жилийн төсөв баталдаг, ингээд л 2 жил алдвал тэгээд л тэр төсөл, тэр том төслүүд тэгээд л энэ 4 жил байхгүй болно л гэсэн үг. Тэгээд энэ төслүүд маань ер нь хоорондоо их уялдаа холбоотой, бие биеийгээ дэмжиж чирч явах ийм эдийн засаг, нийгмийн ач холбогдолтой төслүүд байгаа учраас нэг ингээд цогцоор нь яваад, ингээд нэг дэмжээд, хараад хяналт тавиад ингээд явчихвал уг нь их зүгээр байгаа юм даа.

Д.Амарбаясгалан: Жаргалан гишүүн тодруулга.

Б.Жаргалан: Засгийн газраас оруулж ирж байгаа 3,1 их наядын төсвийн тодотгол дээр бол 474 тэрбум төгрөгийн бараг ТЭЗҮ тавигдчихаад байгаа юм л даа. Тэгэхээр тэр ТЭЗҮ-ээ болохоор ерөөсөө л тийм дэлхийд нэр хүнд бүхий этгээдүүдэд урилга өгөх маягаар шалгаруулна гэсэн тийм л үзэл санаа яваад байх шиг байгаад байгаа. Тэгэхээр бид бол аливаа тийм сонгон шалгаруулалт дээр магадгүй дотоодын ААН-үүдийн оролцоо тодорхой хувьд нь байдаг, дотоодын тэр ажиллах хүчний оролцоо тодорхой хувьд нь байдаг энэ мөнгө бас дотоодынхоо эдийн засагт эргэлдэж байх ийм нөхцөл байдлыг бас бүрдүүлж байх нь чухал гэж харж байгаа юм. Тэгж байж энэ нөгөө манай ААН-үүд болон хүний нөөц маань чадавхажна. Тэгэхээр Засгийн газар энийгээ бас ингээд анхаараасай.

Тэгээд энэ оруулж ирж байгаа төсөл хөтөлбөрүүд дээрээ бас нэг тодорхой илүү ийм танилцуулгуудаа бас илүү чамбай болгох нь зөв байгаад байна. Нэг ганц презентация өгчхөөд, тэгээд тэрнийхээ хүрээнд л ингээд яригдаад байх чинь бол асуудалтай.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нямтайширын Номтойбаяр гишүүн асуултаа асууя. Алга байна. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхбат: Манайхан энэ Төрийн худалдан авах ажиллагааны тухай хуультай л нэлээн тойрч ярьж байна. Энэ дээр бол бас орон нутагт ч тэр ялгаагүй ер нь бол асуудал гардаг. Энэ тендерүүд удаан, олон дахин зарлагддаг, орж ирдэггүй. Зарим нэг үед энэ төрийн байгууллагын төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгэдэг энэ тэр юмнууд гардаг. Энэний хамгийн чухал юм бол ерөөсөө энэ он дамжсан төсвүүд л байдаг шүү дээ. Нэг төсөв хийлгэчихдэг тэр нь ингээд 2, 3 жил

дамжчихсан. Тэрнээс болоод л аж ахуйн нэгжүүдийн сонирхол байхгүй болчихдог. Тэгээд I ТӨК-аар хийлгэнэ. Нөгөөх нь бас нэг дургүй ламд дарж байж сахил хүртээнэ гэдэгтэй адилхан хүчээр нэг юм хийх ийм шаардлага гардаг. Зүгээр энийг заавал төрийн өмчит гэхээсээ илүүтэй өөр ижил төстэй аж ахуй нэгжүүдэд санал болгодог юм уу, өөр чадвартай аж ахуйн нэгжүүдэд санал болгодог юм уу нэг ийм байж болохгүй юу?

2 дугаарт нь эсвэл тухайн жил тендерээ зарлахдаа төсвөө заавал шинэчилсэн байх ёстой гэдэг нэг ийм шаардлага бас тавьж болохгүй юу гэдэг нэг ийм зүйлийг асууя гэж ингэж бодож байна.

2 дугаарт энэ удаагийн төсвийн тодотголд Эрүүл мэндийн сайд ороод ирсэн байна. Би бас энэ завшааныг ашиглаад бас нэг юм асуучихъя. Энэ орон нутагт байгаа энэ нэгдсэн эмнэлгүүд гүйцэтгэлийн санхүүжилтээрээ явсаар байгаад нөгөө өрөнд орчихсон юмнууд байдаг. Бүх аймагт л бараг байгаа юм шиг байна лээ. Тэгээд энэний энэ өрийн асуудлыг Эрүүл мэндийн сайдад бол нэлээн их бичиг ирж байгаа байх аймаг болгоноос. Бид нарт ч ирээд бид нар бас явуулж байгаа, дамжуулж уламжилж байгаа. Тэгэхээр энэний, энэ аймгуудын энэ нэгдсэн эмнэлгүүдийн, эрүүл мэндийн төвүүдийн энэ өрийг энэ удаагийн тодотголоор шийдэх үү? Энийг Эрүүл мэндийн сайд саналаа хүргүүлж байгаа юу? Сангийн яам нь юу гэж үзэж байгаа вэ гэдэг нэг ийм асуулт байна.

2 дугаарт энэ нөгөө нэг алдартай Өмнөговийн нэмэгдүүлсэн орлого төвлөрүүлэлт. Энэ дээр 700 тэрбумыг нэмж төвлөрүүлэх ийм шаардлага өгөөд, нийтдээ 1,4 тэрбум төгрөг Өмнөговь аймаг орлого төвлөрүүлнэ гэхчхэн. Өмнөговь аймаг өнгөрсөн оныхоо 12 сарын 5-нд орон нутгийнхаа хөрөнгө оруулалтыг батлах иргэдийн Төлөөлөгчдийн хурал дээрээ энэ 700 тэрбумаа ингээд баталчихсан байгаа.

Ямар, ямар хөрөнгө оруулалтууд хийгдэх вэ гээд. Тэгэхээр зэрэг эд нарыг гэрээлчихсэн байгаа тэр ААН-үүд энэ хөрөнгийг ер нь яая гэж шийдэж байгаа вэ? Ингээд таг гацаагаад хаях юм уу эсвэл дараа он руу нь шилжүүлэх юм уу энэ дээр бас нэг ямар байр суурьтай байгааг нь сонсох гэсэн юм. Бас Жавхлан сайдаасаа нэг үг бас унагачихмаар байна. Нэмэлт нэг минутаа авчихъя.

Д.Амарбаясгалан: Нэмэлт тодруулга 1 минутаа авъя гэж байна. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүнд нэмэлт 1 минут.

Ц.Мөнхбат: Энэ тодотголоор болохоор дандаа шинэ хөрөнгө оруулалтууд батална гээд ингэчихсэн. Тэгэхээр энэ манай говийн бүсийн авто замын их засварын төслүүдийг хэзээ хийх вэ? Энийг 25 оны төсөв дээр оруулъя гэж бодож байгаа юм уу? Энэ дээр Сангийн сайд та нэг тодорхой хариулт өгөөч гэж хүсэх байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Тэр хувийн компанид ёстой өгч болохгүй. Тэгвэл энд ёстой хэзээ ч батлагдахгүй. 2 удаа зарлалаа, нэг ч оролцогч орж ирээгүй бол ижил төстэй хувийн компанид шууд өгнө гэвэл Их Хурал батлах уу? Тэгээд та бол санаачилж болно шүү одоо. Хэрвээ тэгж болж байна гэвэл тийм. Засгийн газар дээрээс энэ удаа бол энэ боломжгүй гэсэн байгаа.

Тэр төсөв шинэ байх ёстой гэдэг тантай санал нийлж байна. Яг энэ заалтын дагуу Төсвийн тухай хууль дээр орсон энэ чинь 29-ын, 29.2.2 байх. Байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн 2 жилийн хугацаанд 2 жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар төсөвтэй байх ёстой гээд. Өөрөөр хэлбэл дээшээ болчих юм болбол өр...,

төсөвт оруулахгүй гэсэн үг ийм заалттай болсон шүү. Тэгээд өмнө нь энэ чинь 2 жилийн өмнө л ийм болсон. Тэрнээс өмнө болбол бүүр хуучнаараа ч ингээд хамаагүй явчихдаг байсан. Эрүүл мэндийн даатгалын санг яах уу Мөнхсайхан сайд, би тан дээр нэмж яана, тусална.

Энэ хар даа Өмнөговь аймгийн баялаг газар зүйн байрлалаараа тэнд байгаа хэдий ч энэ бол Монголын ард түмний баялаг шүү гэдгийг би олон дахин хэлээд байгаа. Тэгээд 6 аймаг дээр ийм асуудал гардаг болчихсон юм. Өнгөрсөн 4 жил Нэгжийн тухай хуульд өөрчлөлт оруулаад газар зүйн байрлалаараа тухайн орон нутагт байгаа болбол ААНОАТ-ын 40 хувийг нь буцаагаад хуваарилдаг болчихсон юм. Ингээд Өмнөговь аймаг, Дорноговь аймаг, Эрдэнэт, Сэлэнгэ, Дархан ингээд 6 аймаг. 6 аймаг дээр нөгөө стратегийн томоохон нөгөө уул уурхай байдаг энийг дагаад ААН-ийн орлогын албан татвар Өмнөговийн татварын алба тэнд хураагаад байгаа юм юу ч байхгүй. Татварын ерөнхий газар энэ Том аж ахуйн нэгжийн татварын орлогын бүрдүүлэлтийн газар энэ татвараа төвлөрүүлээд, тэгээд аймгууд руу хуваарилдаг байхгүй юу. Тийм. Тэгээд энэ уг нь Засгийн газраас дэмжигдээгүй хууль юм. Тэгээд Их Хурал дээр батлагдчихсан. Одоо бид мөрдөхөөс өөр арга байхгүй.

Харин энийг ингээд цаашидаа ингээд жоохон буруу хандлага яваад, зөвхөн энийг Өмнөговь аймагт зарцуулах ёстой, Эрдэнэтийнхийг Эрдэнэтэд нь зарцуулах ёстой, өөр татаас авдаг аймгууд руу зарцуулж болохгүй шүү гэх юм болбол энэ манай энэ нэгдмэл улс чинь нөгөө Америк шиг 21 нэгдсэн аймгийн улс болж хувирах байх. Тийм учраас бид нар суурь зарчмаа ингэж алдаж болохгүй. Тийм учраас яг Төсвийнхөө хуулийн дагуу нэмэгдсэн орлого, тэгээд суурь зардал 2 эндээсээ тэр аль багынх нь 70 хувиар нь бид нар буцаагаад хуваарилж байгаа.

Өмнөговь аймагт 52 тэрбум төгрөг хуваарилагдаж байгаа. Бусад нь улсын нэгдсэн төсөвт хуулийн дагуу буцаагаад төвлөрүүлнэ гэсэн үг.

Харин бид одоо хэрвээ нэг иймэрхүү буруу хандлага яваад байвал ирэх төсөв дээрээс энэ яг Улсын Их Хуралд оруулж ирж байгаа тэр стратегийн том уурхайнуудтайгаа эндээс аж ахуйн нэгжүүдийг нь батлуулж аваад жагсаалтаар нь, тэгээд орон нутаг руу тэр 40 хувийг хуваарилуулахыг ер нь зогсоомоор байгаа юм. Зогсоомоор байгаа юм. Эндээс нэгдсэн төсвөөрөө эндээ хийж аваад, тэгээд Их Хурал өөрөө эндээ хуваарилалтаа хийдэг. Ингээж нэг ойлголтыг нь зөв болгож өгөхгүй бол ингээд буруу хандлага бий болох гээд байна.

Тэр юуны хөрөнгө оруулалтын говийн зам гэж байна. Тэрийг 25 оны төсөв дээр ярилцаж, энд Засгийн газар дээр бодлогын яам нь ямар санал оруулж ирэх нь вэ, төсвийн боломж ямар байх нь вэ. Одоо бол эцэслэж би хариу өгөх боломж байхгүй.

Өмнөговь аймаг баталчихсан гэж байгаа юм. Батлах ёсгүй юм баталчихсан байхгүй юу. Тэр төсвийн орлогоо ингээж давж биелнэ гээд тэрэндээ тааруулаад хөрөнгө оруулалтаа тэгж хийж болохгүй. Эндээс хэлсэн байгаа шүү дээ, ингээж тодотгол хийж болохгүй шүү гэж. Тэгээд энийг зөрчиж хийсэн ийм зөрчилтэй асуудал үүсчихсэн байгаа шүү. Тийм учраас одоо энэ тодотголын дараа дагаж хийгдэх ёстой.

Д.Амарбаясгалан: Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан нэмж хариулъя.

Т.Мөнхсайхан: Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн салбар 2021 оноос хойш нэг худалдан авагчийн тогтолцоо буюу гүйцэтгэлийн санхүүжилт рүү

шилжсэний буянаар бид нар ковидын давлагааг маш сайн амжилттай давсан. Ялангуяа омикроны давлагааныг давсан. Үүнд бол маш их санхүүжилт зарцуулагдсан. Үүнтэй холбоотойгоор 2021 оноос хойш өнөөдрийг хүртэл Эрүүл мэндийн даатгалын санд 218 тэрбумын өр өнөөдрийн байдлаар үүссэн байгаа. Тэгэхээр энэ асуудлыг шийдэх асуудлыг сая тодотголд оруулсан боловч ер нь өнөөдөр энэ хийж хэрэгжүүлэх том төслүүдээ явуулахад илүү их хөрөнгө оруулалтаа хийнэ. Энэ 218 тэрбумын өрийн асуудлыг ирэх жилийн төсөвт тусгаж өгнө гэдэг байдлаар ер нь Засгийн хурал дээр шийдэгдсэн. Гэхдээ энэ аймаг орон нутгуудад үүсчихсэн байгаа өрийн асуудал бол өөр асуудал. Аймгийн нэгдсэн эмнэлэг буюу Бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүд маань ажлаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан:

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн. Нэмэлт тайлбар хариулт байна уу? Нэмэлт хариулт Тогтмолын Мөнхсайхан сайд.

Т.Мөнхсайхан: Энэ нь болохоор аймгийн нэгдсэн эмнэлгүүд маань ажлаа сайн хийж, гүйцэтгэлээ авч чадахгүй байна л гэсэн үг. Тэгээд ингээд ажлаа сайн хийснийхээ хэрээр гүйцэтгэлийнхээ санхүүжилтийг авч чадахгүй байгаа тохиолдолд бид нар мөнгийг нь тавьж өгөөд байх юм бол энэ орон нутагт нөгөө тусламж үйлчилгээ хөгжих асуудал чинь орхигдсон хэвээрээ л байх болно. Улаанбаатарт төвлөрсөн тусламж үйлчилгээ ард иргэд чирэгдэл учирсаар л байх болно. Тийм учраас бид нар энэ дээр өөр бодлогыг явуулж, аймгийн нэгдсэн эмнэлгүүдийг бодлогын хувьд, хүний нөөцийн хувьд, тоног төхөөрөмжийн хувьд дэмжиж, гүйцэтгэлээ сайн хийдэг болдог энэ бодлого л бид нарт тэгвэл их чухал байгаа.

Энэ рүү нь чиглэсэн арга хэмжээнүүдийг энэ жил авч, бид нар энэ зарим нэгэн аймгуудад байгаа бүх аймаг

биш. Гүйцэтгэлээ сайн хийгээд өнөөдөр илүү гарсан мөнгө санхүүгээ тоног төхөөрөмж, их засвар юмандаа зарцуулаад явж байгаа аймгууд бас нэлээдгүй байгаа. Тэгэхээр бид нар цаашидаа бүх аймгийг ийм түвшинд хүргэхийн тулд бодлогын хувьд хүний нөөц, тоног төхөөрөмжийн хувьд дэмжиж ажиллаж байж аймагтаа үзүүлэх ёстой тусламж үйлчилгээнүүдийг нь үзүүлдэг болгох талд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тодорхой хариулна шүү товчхон. Манай нөгөө хэлэлцэх асуудлын маань цаг тэр дэлгэцийн баруун дээд булан дээр явдгийг гишүүд бас анзаарчих нь зүйтэй байх. Нийт асуулт, хариулт энэ цагтаа багтаж хэлэлцэгдэх ёстой байдаг. Тийм учраас цагийг нарийн тооцож яриад байгаа. Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуултаа асууя.

М.Бадамсүрэн: 2 асуулт байна. 1 дүгээрт энэ Худалдан авахын хуультай холбоотой энэ их чухал хууль л даа. Ялангуяа энэ зах зээлийн эдийн засагт. Ерөөсөө мэдээллийн эрх чөлөө буюу төр төсвийн эрх чөлөөг улам бэхжүүлэх хэрэгтэй энэ мэдээллийн ил тод байдлыг.

2 дугаарт нь энэ хувийн хэвшлийн өрсөлдөх боломж эрх чөлөөг хамгийн их тэлж байх ёстой. Ерөөсөө энэ зах зээлийн эдийн засгийн суурь зарчим. Тийм учраас энэ ер нь аж ахуйн нэгж гүйцэтгэгчийг сайн гүйцэтгэгч шалгаруулна гэдэг бол энэ хийх ажлынхаа ер нь бараг дийлэнхийг хийсэн л гэсэн үг. Хэрвээ ингэж чадахгүй бол хяналтаа сайн тавьж чадахгүй байгаа тохиолдолд энэ ажил маань үр дүнгүй байгаа юм. Тэгэхээр би энэ дээр эхний 1 дүгээр асуулт нь зүүн бүс рүү зорчиж үзсэн хүн бүрийн жолооч бүрийн мэддэг энэ тамын 50км, Булганы 27км гээд байгаа нэг нь Чайна Жо Инженеринг гээд компани, нэг нь Хансун зам гээд компани 12-оос 16 оны Засгийн газрын үед энэ

Хөгжлийн банкны санхүүжилтээр энийг гүйцэтгэсэн. Тэгээд энэний 1 дүгээрт бол Дэлхийн банкны санхүүжилтээр ингээд энийг гүйцэтгэхээр болсон тамын 50-ийг. Гэхдээ одоо болтол худалдан авах ажиллагаа нь шалгараагүй байна. Энэ тал дээр мэргэжлийн яамнаас мэдээлэл авъя.

2 дугаарт нь энэ Булганы 27км гээд энэ магадлалын дүгнэлт нь гараад, зураг төсөв нь хийгдчихсэн байгаа 38,1 тэрбум төгрөг. Энэ нь хэзээ энэ тодотгол дээр суух боломжтой юу эсвэл 25 оны төсөв дээр үү? Энэний талаар 1 дүгээрт асуулт асууя.

2 дугаарт нь энэ Худалдан авахын хуулийн үйлчлэл цаашидаа энэ зээл тусламж ч бай, төсвийг ч бай бусад ялангуяа энэ хүний гараар бүтээгдээгүй уул уурхайн баялаг, газрын тосны баялаг, тэгээд энэ төрөөс тусгай зөвшөөрөл лиценз эзэмшиж байгаа энэ ААН-үүдийг худалдан авах ажиллагааг бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энийг энэ хуулийн үйлчлэлд хамруулах шаардлагатай гэж бол үзэж байгаа. Ер нь иргэд ийм саналтай байгаа. Яагаад гэхээр үүний ард ил тод байдал байхгүй болж байна, хувийн ашиг сонирхол буюу албан тушаалтны ашиг сонирхол энд бол байгаа гэдэг ийм хардалт бол нийгэмд их байгаа.

Мөн газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ бол төртэй байгуулсан шүү дээ, Засгийн газартай байгуулсан гэрээ. Тэгээд энэ гэрээгээр байгуулж байгаа учраас энэ газрын доор байгаа баялгийг ашиглах зардал өртөг нь гараад, энийг өртгөө дараад, дараа нь илүү гарснаас нь Монгол Улсад 40 хувь, тухайн компани 60 хувь гээд ийм ашиг хуваах зарчмаар явж байгаа. Тийм учраас манайх бол энд хувь нийлүүлсэн гэсэн үг. Энэ утгаараа энэ хуулийн үйлчлэлд хамруулж өгөх нь зүйтэй гэж үзэж байгаа. Ингэхгүй бол одоо бодит байдал дээр ингээд аудит ямар дүгнэлт гаргадаг юм их учир битүүлэг явдаг энэ газрын тосны

олборлолт дээр. Энэ дээр зардлаа үлэмж хэмжээгээр нэмэгдүүлсэн гэж би бол хардаж байгаа.

Ер нь гадаадын хөрөнгө оруулалт гэдэг бол хөрөнгөө оруулаад, ашигаа аваад явахыг хэлдэг болохоос биш бүгд туслан гүйцэтгэгчээ дагуулж ирдэг, бүх ажилчдаа дагуулж ирдэг, Монголчуудын хийж чадах ёстой ажлыг бүгдийг нь энэ гадаадын хөрөнгө оруулалттай нэртэй компаниуд хийдэг. Монголчуудын боломжийг дээд зэргээр ингээд өөрсдөө ашигладаг. Тэгээд энэ дээр нь хяналт тавихын тулд бид нар энэ Худалдан авахын хуулийн үйлчлэлд оруулж, энэ зардлыг нь хянах ёстой гэж үзэж байгаа. Ингэвэл энэ бол жинхэнэ хөрөнгө оруулалт. Түүнээс биш яг ингэж явах юм бол энэ бол Монголын баялгийг цөлмөх үйл ажиллагаа.

Д.Амарбаясгалан: Хариулт. Туваан сайд хариулт өгөх үү, үгүй юу? Үг хэлсэн гэж үзэж байна. Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. 5 гишүүн нэр ирүүлсэн байгаа. Нэр ирүүлсэн дарааллаар индэрт үгээ хэлнэ. Ингээд Батын Батбаатар гишүүнийг 2 дугаар индэрт урьж байна. Алга байна. Лувсанжамцын, Лувсанжамц гишүүн, Ганзоригийн Лувсанжамц гишүүн. Намын бүлгээс нэр ирсэн байсан. Нэрээ өгөөгүй гэж байх юм. Мөнхбаатар гишүүн яасан юм бол? Бүлгээс ирсэн бичгийн дагуу энэ нэр орсон тийм ээ. Тэгэхээр Дэгийн тухай хуулиараа Улсын Их Хурлын гишүүн үг хэлэх эрхээ өөрөө эдэлнэ, бусдад шилжүүлэх боломжгүй. Тэгэхээр Лувсанжамц гишүүн нэрээ өгөөгүй гэж байна хаслаа. Бадрахын Найдалаа гишүүн 2 дугаар индрээс үг хэлье.

Б.Найдалаа: Энэ жсоохон юу яаж байх шиг байна. Нөгөө нэр өгөхдөө жсоохон будилаан гарч байх шиг байна. Асуулт дээр өгсөн байх гэж бодсон, бас дэгийг эсвэл яасан уу, жсоохон үл ойлголцол гарч байх шиг байна.

Д.Амарбаясгалан: Тэгвэл хасъя. Одонгийн Цогтгэрэл гишүүн. Үг хэлнэ. 1, 2, 3, байхгүй байна. Дашидондогийн Ганбат гишүүн үг хэлнэ. Байхгүй байна. Ингээд гишүүд үг хэлэх дууслаа.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, 5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, 6.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 7.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 8.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, 9.Монгол Улсын Засгийн газрын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 10.Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 11.Төр хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 12.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай, 13.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, 14.“Төрийн өмчийг Нийслэлийн өмчид шилжүүлэх тухай”, 15.““Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна.

Санал хураалт. Санал хураалтад 104 гишүүн оролцохоос 44 гишүүн дэмжжээ, санал унасан байна. Горимын санал Хассуурийн Ганхуяг гишүүн, Гонгорын Дамдинням гишүүн нар горимын санал.

Х.Ганхуяг: Дарга энэ техник шинэчлэлээс хойш бол ерөнхийдөө ингээд санал өгөхөөр дэмжээд байхад унаад байх юм. Тэгээд энэ дээрээ нэг анхаарал хандуулахгүй бол манай энэ Техникийн хэлтсийнхэн. Дахиад санал хураалт явуулж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Хассуурийн Ганхуяг гишүүн дэмжсэн санал дээр, татгалзсан санал дээр гарсан байна тийм ээ. Гонгорын Дамдинням гишүүн горимын санал гаргах нь. Ижилхэн.

Г.Дамдинням: Хүчингүй болгоё гэж байгаа юм. Нэг ижилхэн санал гарчихлаа л даа.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр яах юм бэ?

Г.Дамдинням: Одоо дахин санал хураана л гэсэн үг. Ганхуяг гишүүний гаргасан горимын саналаар энэ саяын санал хураалтыг хүчингүй болгоод, дахин санал хураах горимын санал гаргаж байна.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр хүчингүй, саяын хураасан саналыг хүчингүй болгох горимын саналаар санал

хураалтыг эхлүүлбэ. 54 гишүүн дэмжсэнээр санал хураалт хүчингүй боллоо. Ингээд үндсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд нь хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалтад оролцсон гишүүдийн 55 буюу 52,9 хувиар санал хэлэлцэх нь зүйтэй гэж дэмжигдлээ.

Ингээд хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

16.35 цаг

Тав. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэх асуудал 5. Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэж эхэлнэ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22.1.3-д Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн, нам, эвслийн бүлгээс ирүүлсэн саналыг нэгтгэн нам, эвслийн бүлэгтэй зөвшилцөж, Байнгын хорооны бүрэлдэхүүний талаарх саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах гэж заасны дагуу зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн

22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэлийг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Очирбатын Амгаланбаатарыг Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны, Хишигдэмбэрэлийн Тэмүүжинг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэлийг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны, Очирбатын Амгаланбаатарыг Амгаланбаатар, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 50 оролцсон гишүүдээс 55 гишүүн дэмжсэнээр 52,9 хувиар дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

16.38 цаг

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА